

ХУУЛЬЧДЫН
ӨӨРӨӨ
УДИРДАХ ЁСНЫ
БАЙГУУЛЛАГА

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ
БОДЛОГЫН СУДАЛГАА



ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГА

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ БОДЛОГЫН СУДАЛГАА

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

МУИС-ийн ХЗС-ийн НЭЗТ-ийн багш,
хуульч Б.БАЯЛАГМАА (LL.M)

Хуульч, өмгөөлөгч Б.АНИРМАА (LL.B)

Хуульч, өмгөөлөгч Б.НАРАНЦЭЦЭГ (LL.B)

Хуульч, өмгөөлөгч Э.ЭНХЦЭЦЭГ (LL.B)

Улаанбаатар хот
2021 он

ННА 67.3
ДАА 340.009
Х-758



ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГА

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ БОДЛОГЫН СУДАЛГАА

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

МУИС-ийн ХЗС-ийн НЭЗТ-ийн багш, хуульч Б.БАЯЛАГМАА (LL.M)

Хуульч, өмгөөлөгч Б.АНИРМАА (LL.B)

Хуульч, өмгөөлөгч Б.НАРАНЦЭЦЭГ (LL.B)

Хуульч, өмгөөлөгч Э.ЭНХЦЭЦЭГ (LL.B)

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-4-2

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Шударга ёсыг бэхжүүлэх чиглэлээр сүүлийн арван жилийн хугацаанд хийгдсэн томоохон шинэтгэлүүдийн нэг нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага бий болсон явдал юм. Хуульчдын эрх зүйн байдлын тухай хууль 2012 онд батлагдаж, Монголын Хуульчдын холбоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээр хуульчдын нийгэмд үзүүлэх нөлөө, оруулах хувь нэмэр нэмэгдэж байгаа билээ. Тухайлбал, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шүүхийн тухай хууль, эрүүгийн болон захиргааны хуулийг шинэчлэн найруулахад хуульчдын идэвх, оролцоо өндөр байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Энэ онд Монгол Улсын Засгийн газар Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн бариад байна. Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, бүтэц, шийдвэр гаргах процесс зэрэг асуудлын хүрээнд бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, хуульч Б.Баялагмаа, хуульч судлаач Б.Анирмаа, Б.Наранцэцэг Э.Энхцэцэг нар харьцуулан судалж, бодлогын санал, зөвлөмж боловсруулсныг уншигч Та бүхэнд толилуулж байна.

Уг судалгаагаар Монголын Хуульчдын холбооны эрх зүйн өнөөгийн орчин, чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэн шинжилж, хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн орчин, бүтэц, чиг үүргийн хүрээнд АНУ, Австрали, Япон болон бусад постсоциалист орны туршлагыг харьцуулан шинжилсний дүнд хуулийн төслийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах тодорхой саналуудыг томъёолон танилцуулахыг зорилоо.

Бодлого боловсруулах үйл ажиллагаа нь олон талын, тэр тусмаа хуульчдын оролцоотой байж гэмээ нь хууль тогтоомжийн чанар сайжирч, хуульчдын мэргэжлийн үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч, мэргэжлийн хариуцлага дээшилж, улмаар хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ хэмээн найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

УДИРТГАЛ	8
Нэг. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ОНОВЧТОЙ БОЛГОХ ШААРДЛАГА	11
1.1. Монголын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтын зарим асуудал	11
1.2. Монголын Хуульчдын холбооны эрх барих дээд байгууллага дахь хуульчдын оролцоо	17
1.3. Монголын Хуульчдын холбооны удирдлагыг сонгоход анхаарах асуудал	22
Хоёр. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	26
2.1. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын онцлог, гишүүнчлэл	26
2.1.1. АНУ-ын Хуульчдын холбоо	36
2.1.2. Австрали Улсын Хуульчдын холбоо болон Хуульчдын нийгэмлэг	39
2.1.3. Япон Улсын Хуульчдын холбоо	41
2.1.4. Постсоциалист орнуудын Хуульчдын холбоо	42
2.2. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн чиг үүрэг	45
2.2.1. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж буй байдал	45
2.2.2. Өмгөөлөгчийн гишүүнчлэлтэй холбоодын чиг үүрэг, тэдгээрийн онцлог	49
2.3. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын бүтэц, зохион байгуулалт	52
2.3.1. АНУ-ын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт	52

2.3.2. Австрали Улсын Хуульчдын холбоо болон Хуульчдын нийгэмлэгийн бүтэц, зохион байгуулалт	60
2.3.3. Япон Улсын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт	66
2.3.4. Постсоциалист орнуудын Хуульчдын холбоодын бүтэц, зохион байгуулалт	70
2.4. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлагыг сонгох тогтолцоо (АНУ, Австрали Улс, Япон Улс, ОХУ)	85
2.4.1. Эрх барих дээд байгууллага дахь төлөөлөгчийг сонгох	85
2.4.2. Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүд болон Ерөнхийлөгчийг сонгох	87
ДҮГНЭЛТ	91
САНАЛ	95
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	100

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	Хуульчдын холбооны онцлог (хуулийн этгээдийн хэлбэр, гишүүнчлэлээр)	26
Хүснэгт 2.	Хуульчдын холбооны онцлог (гишүүнчлэлийн төрлөөр)	29
Хүснэгт 3.	АНУ-ын Хуульчдын холбооны гишүүнчлэлийн жилийн хураамж	37
Хүснэгт 4.	Гадаад улсуудын Хуульчдын холбоодын чиг үүрэг	46
Хүснэгт 5.	Улс орнуудын Хуульчдын холбоодын бүтэц	83
Хүснэгт 6.	Гадаад орнуудын Хуульчдын холбоодын Хурлын төлөөлөгчийг сонгож буй байдал	86

ЗУРАГ

Зураг 1.	МХХ-ны бүтэц, зохион байгуулалт	13
Зураг 2.	ХЭЗБТХ-ийн төсөлд тусгасан МХХ-ны бүтэц	16
Зураг 3.	Хуульчдын Их хурал дахь төлөөлөл	20
Зураг 4.	АНУ-ын Хуульчдын холбооны бүтэц	52
Зураг 5.	Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны бүтэц	57
Зураг 6.	Австрали Улсын Хуульчдын холбооны бүтэц	60
Зураг 7.	Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн бүтэц	63
Зураг 8.	Япон Улсын Хуульчдын холбооны бүтэц	66
Зураг 9.	ОХУ-ын Хуульчдын холбооны бүтэц	70
Зураг 10.	Литва Улсын Хуульчдын холбооны бүтэц	76
Зураг 11.	Беларусь Улсын Хуульчдын зөвлөлийн бүтэц	80

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МХХ	Монголын Хуульчдын холбоо
МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн холбоо
ХЭЗБтХ	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
ӨмтХ	Өмгөөллийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс

УДИРТГАЛ

Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага нь хуульчдын эрх ашгийг төрийн болон төрийн бус байгууллагын өмнө төлөөлөн хамгаалж, хуульчийн боловсрол, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх¹ замаар олон нийтийн эрх ашгийг хамгаалж, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх гол баталгаа болдог.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар боловсруулсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (ХЭЗБТХ)-ийг Улсын Их Хурал (УИХ)-аас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталснаар хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн үндэс бүрдсэн юм. Тус хууль нь 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсноор² хуульч сонгон шалгаруулах харилцааг зохицуулж байсан Хуульч сонгон шалгаруулах тухай хууль, мөн өмгөөллийн байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох, өмгөөллийн үйл ажиллагаанд холбогдох харилцааг зохицуулах зорилготой Өмгөөллийн тухай хууль³ тус тус хүчингүй болжээ. ХЭЗБТХ -ийн дагуу 2013 онд байгуулагдсан Монголын Хуульчдын холбоо (МХХ) нь заавал гишүүнчлэлтэй байх ба хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах, хууль зүйн дээд боловсролын байгууллагыг магадлан итгэмжлэх, хуульчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, хуульчдын эрх ашгийг хамгаалах өргөн чиг үүрэгтэй нийтийн эрх зүйн хуулийн этгээд байхаар зохицуулагдсан.

¹ Comparative analysis of Bar Associations and Law Societies in Select European Jurisdictions. World Bank Document

² УИХ-аас 2013.01.17-ны өдөр баталсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2013.04.15-ны өдөр болгон өөрчилсөн.
<https://legalinfo.mn/mn/detail/8661>.

³ Өмгөөллийн тухай хууль, 2002.05.16.
<https://legalinfo.mn/mn/detail/13>.

Хуульчдын анхдугаар Их хурлыг 2013 оны 9 дүгээр сарын 06-08-ны өдрийн хооронд зохион байгуулан, МХХ-ны дүрэм, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, гишүүн хуульчийн төлбөл зохих татварын хэмжээг тус тус баталж, МХХ-ны анхны Ерөнхийлөгчийг сонгосон юм.⁴ Тухайн цаг үеэс эхлэн хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж иржээ.

МХХ байгуулагдсанаас хойш хоёр жилийн дараа буюу 2015 онд Засгийн газраас өмгөөллийн үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулах санаачилга гаргаснаар Өмгөөллийн тухай хууль (ӨмтХ)-ийн төслийг боловсруулан батлах үйл явц эхэлж, 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр УИХ-аас уг хуулийг баталснаар өмгөөлөгчдийн мэргэжлийн байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах болсон. Ийнхүү Монголын өмгөөлөгчдийн холбоо (МӨХ)-г дахин байгуулж, уг холбоо нь МХХ-ны зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болсноор хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг хязгаарлагдаж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газраас ХЭЗБтХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн билээ. Тус хуулийн төслийг боловсронгуй болгох, батлах үйл явцыг хөндлөнгийн хараат бус судалгаа, шинжилгээгээр хангах, хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцооны үндсэн асуудлаар харьцуулсан судалгаа хийж бодлогын санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгааны хүрээнд дараах үндсэн зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- МХХ-ны одоогийн эрх зүйн орчин, чиг үүргийн хэрэгжилтийг үнэлж, шинжлэх;

⁴ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны веб хуудас. <https://mojha.gov.mn/newmojha/?p=591>.

- Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх зүйн орчин, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцооны хүрээнд гадаад орнуудын туршлагыг судлах;
- ХЭЗБтХ-ийн төсөлд тусгагдах боломжтой тодорхой саналыг томъёолох зэрэг зорилт хамаарна.

Бид хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо хэрэгжүүлж буй гадаад орнуудын туршлагыг хууль зүйн харьцуулсан судалгааны аргын дагуу судалж, МХХ-ны бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог тодорхойлоход дэмжлэг үзүүлэх тодорхой саналууд гаргасан болно.

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ОНОВЧТОЙ БОЛГОХ ШААРДЛАГА

1.1. МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Монголын Хуульчдын холбоо нь ХЭЗБТХ-д заасан чиг үүргээ өөрийн бүтцийн байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх тул Холбооны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн бүтэц, зохион байгуулалт ихэнх оронд ижил төстэй байх бөгөөд эрх барих дээд байгууллага (*supreme body*), ерөнхийлөгч (*president*), гүйцэтгэх байгууллага (*executive body*), хяналтын байгууллага (*controlling body*), мэргэжлийн хариуцлагын байгууллага (*disciplinary body*) болон хороод, бусад зөвлөх байгууллага (*committees and advisory bodies*)-аас бүрдсэн байдаг.⁵ ХЭЗБТХ-ийн анхны төсөл, үзэл баримтлал, танилцуулгад тодорхойлсноор⁶ МХХ нь хуулиар тодорхойлсон чиг үүргээ хуульчдын Их хурал, Ерөнхийлөгч, Зөвлөл, Хяналтын зөвлөл, Тамгын газар, Хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хуульчдын Их хурал нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх барих дээд байгууллага байна. Тус хуралд МХХ-нд бүртгэлтэй 500 хүртэлх төлөөлөгч оролцох бөгөөд МХХ-ны дүрэм, хуульчийн мэргэжлийн нэгдсэн стандарт тогтоож буй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм

⁵ Comparative analysis of Bar Associations and Law Societies in Select European Jurisdictions. World Bank Document


⁶ ХЭЗБТХ-ийн танилцуулга, үзэл баримтлал, 2021.
<https://huulich.blogspot.com>, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн эргэн тойронд.

батлах, Ерөнхийлөгчийг сонгох, хуульчдын татварын хэмжээг тогтоох үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

- Ерөнхийлөгч нь хуульчдын ашиг сонирхлыг гадаад болон дотоод харилцаанд, төрийн болон төрийн бус байгууллага, бусад гуравдагч этгээдийн өмнө төлөөлөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Гадаад харилцаанд бусад улсын хуульчдын өөрөө удирдах байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, дотоод харилцаанд хуульчдын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өргөх, тэдний нэр хүнд унахаас сэргийлэх, түүнчлэн хуульчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Зөвлөл нь хуульчдын дагаж мөрдөх нэгдмэл бодлого, стандартыг тодорхойлж батлах, холбоог удирдлагаар хангах, гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Хяналтын зөвлөл нь холбооны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Тамгын газар МХХ-ны өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангаж ажиллана.
- Хороо нь Холбооны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд чиг үүргийн болон сайн дурын хороодоос бүрдэнэ. Чиг үүргийн хороог заавал хуулиар байгуулахаар тодорхойлсон ба үүнд Ёс зүйн, Хариуцлагын, Шалгалтын хороод хамаарна. Хариуцлагын хороог заавал байгуулах бөгөөд хуульчдын нэгдсэн стандарт бүхий хариуцлагын тогтолцоо бий болгох, хөндлөнгийн гишүүдээр маргааныг шийдвэрлүүлэх замаар хуульчдын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлсэн.

ХЭЗБтХ 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд МХХ-ны бүтэц, зохион байгуулалтыг Зураг 1-д үзүүлснээр тодорхойлсон.

Зураг 1. МХХ-ны бүтэц, зохион байгуулалт
(Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга⁷
хэрэгжиж эхлэхээс өмнөх)



УИХ-аас Өмгөөллийн тухай болон Шүүхийн тухай хуулиудыг батлахдаа ХЭЗБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь МХХ-ны хэрэгжүүлэх чиг үүргийг хумьж, анх 2012 оны хуулиар тодорхойлсон хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын өргөн хүрээний буюу чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үзэл баримтлал нь алдагдсан байна. Тухайлбал:

1. МХХ-ны өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг МӨХ-нд шилжсэн.

Засгийн газраас боловсруулсан ӨмтХ-ийн төсөлтэй холбоотойгоор хуульчдын дунд хуулийн төслийг дэмжсэн, эсэргүүцсэн зөрүүтэй байр сууриуд үүссэн байна. Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгаа нь бие даасан ӨмтХ-иар бус харин өмгөөлөгчийн ажлын талбар болох эрүү, иргэн, захиргаа, шийдвэр гүйцэтгэл зэрэг процессын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулснаар хэрэгжинэ гэдэг хуульчдын нэгдсэн

⁷ Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021.01.15-ны өдөр батлагдан, 2021.03.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

байр суурь байсан⁸. Гэсэн хэдий ч ӨмтХ-ийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталжээ. Нөгөөтээгүүр ӨмтХ-ийн төслийг хуульчдын дунд хэлэлцүүлэх явцад дахин шинээр “холбоо” байгуулснаар нийтийн эрх зүйн хуулийн этгээдүүдийн чиг үүрэг давхцах, хуульчид хоёрдмол гишүүнчлэлтэй болох зэрэг сөрөг үр дагаврууд үүсэж болох талаар⁹ хуульчид байр сууриа илэрхийлж байсан байна. Учир нь шинэ ӨмтХ хэрэгжиж эхэлснээр шүүхэд төлөөлөх эрх олгох, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий МӨХ байгуулагдсан. Энэ нь МӨХ болон МХХ-ны гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог ХЭЗБТХ-ийн төсөлд зохицуулах шаардлага үүсгэсэн байна.

2. Хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцооны нэгдмэл стандарт тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн.

МХХ-ноос 2013 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч болон бусад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм баталсан юм. Энэ дүрмийн хүрээнд хуульч бүр эрхэлж буй албан тушаал, ажил үүргээс үл хамаарч үйл ажиллагаандаа зайлшгүй дагаж мөрдөх, түүнийг зөрчсөн тохиолдолд хуульчид мэргэжлийн хариуцлага хүлээлгэх нэгдсэн тогтолцоо бий болгохыг зорьсон. Одоогийн байдлаар шүүгч, прокурор, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг тус бүрийн харьяалсан байгууллага шийдвэрлэж байгаа нь хуульчийн хариуцлагын тогтолцооны шалгуурыг хангахгүй байна. Тодруулбал, хуульчийн хариуцлагын тогтолцоо нь дараах дөрвөн шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд:¹⁰

⁸ МХХ, Хууль дээдлэх ёсны баталгаа: Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага, УБ., 2019, 11 дэх тал.

⁹ МХХ-ны Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооноос гаргасан санал, 2015.10.13.

¹⁰ О.Мөнхсайхан, “Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйгээ зөрчсөн ч хариуцлага хүлээдэггүй болох уу?” нийтлэл, “Хууль дээд ёсны баталгаа: хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага” ярилцлага, нийтлэлийн эмхэтгэл, МХХ, УБ., 2019, 81 дэх тал.

1. Энэ тогтолцоо нь ёс зүйн зөрчил гаргасан хуульчдад зайлшгүй хариуцлага хүлээлгэдэг байх;
2. Хуульчийн асуудал шийдвэрлэж байгаа бүрэлдэхүүн нь өөрөө олон нийтийн итгэл хүлээхүйц хөндлөнгийн байх;
3. Уг асуудлыг шийдэж байгаа хороо нь хараат бус, бие даасан байх;
4. Энэ маргааныг нарийвчилсан процессоор шалгаж шийдвэрлэж байх ёстой.

Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагууд дотроо мэргэжлийн хариуцлагын байгууллага байгуулсан нь бие даасан, хөндлөнгийн хараат бус бүрэлдэхүүнтэйгээр хуульчид холбогдох маргааныг шийдвэрлэх нэгдмэл тогтолцоог үгүй болгосон байна.

Мөн Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр Мэргэжлийн хариуцлагын хороо, түүний ажиллах журмыг зохицуулж байсан ХЭЗБТХ-ийн 7 дугаар бүлэг бүхэлдээ хүчингүй болсон. Тус хорооны ажиллах журмыг хуулиар хүчингүй болгосноор МӨХ-ны гишүүн бус, шүүхэд төлөөлөх эрхгүй хуульчдын¹¹ мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг харьяалан шийдвэрлэх байгууллага, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндэс тодорхойгүй болсон.


Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульч мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэх болон түүний мэргэжил, ур чадварын хувьд эргэлзээ үүссэн (чадамжгүй болсон) эсэх гэсэн хоёр төрлийн маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй¹² хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын бүтцийн салшгүй хэсэг болдог. Гэтэл ХЭЗБТХ-ийн төсөлд “Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо”-г

¹¹ Хуульчдын нэгдсэн бүртгэлийн 2020.12.31-ний өдрийн байдлаарх мэдээлэлд “Бусад хуульч” бүлэгт хамаарах 2,181 хуульч бүртгэлтэй байх бөгөөд энэ нь Хуульчдын холбооны нийт гишүүний 37 хувийг эзэлж байна. МХХ-ны веб хуудас <https://www.mglbar.mn/content/35>.

¹² О.Мөнхсайхан, “Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн нь” өгүүлэл, “Хууль дээдлэх ёсны баталгаа: Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага” ярилцлага, нийтлэлийн эмхэтгэл, МХХ, УБ., 2019, 86 дахь тал.

байгуулахгүй байхаар (Зураг 2-ыг харна уу), МХХ-ны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Зураг 2. ХЭЗБтХ-ийн төсөлд тусгасан МХХ-ны бүтэц



Хуульчийн “Мэргэжлийн хариуцлагын хороо” байгуулах талаар зохицуулаагүй байгаа нь МХХ-ны өмгөөлөгч бус “бусад хуульч” гишүүний мэргэжлийн үйл ажиллагаанд хариуцлага тооцох тогтолцоо тодорхойгүй, үүссэн байгаа асуудлыг зохицуулалтгүй хэвээр үлдээх хууль зүйн эрсдэл үүсгэж болзошгүй байна.

Түүнчлэн МХХ нь хуулиар тодорхойлсон чиг үүргээ сайн дурын болон чиг үүргийн хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Харин ХЭЗБтХ-ийн төсөлд хороодоос гадна “нэгж” байгуулан ажиллуулж болохоор зохицуулсан боловч эдгээрийн хэрэгжүүлэх чиг үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлоогүй байна.

Хууль, эрх зүйн орчны хувьд дээр үүссэн нөхцөл байдлуудаас гадна МХХ гишүүнчлэлийн хураамжийн хүрээнд гишүүдэд санал болгох үйлчилгээний талаарх зохицуулалтыг МХХ-ны дүрмээр зохицуулаагүй байна. Европын хуульчдын болон Хуулийн нийгэмлэгүүдийн зөвлөл (*The Council of Bars and Law Societies of Europe*)-ийн судалгаанаас үзэхэд Хуульчдын холбоо чиг үүрэгтээ хамаарах дараах үйлчилгээнүүдийг гишүүддээ санал болгодог байна. Үүнд¹³:

¹³ Comparative analysis of Bar Associations and Law Societies in Select European Jurisdictions. World Bank Document

- Хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүний эрхийг дээдлэн хамгаалах;
- “Хуульчид бол үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх хамгийн шилдэг өмгөөлөгч” болох талаар олон нийтэд сурталчлах;
- Хуульчийн мэргэжлийн дадлага болон хуульчийн эрх олгох үйл ажиллагаа зохион байгуулах;
- Хуульчийн мэргэжлийн дадлага олгох, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавих, хариуцлагын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх;
- Хуульчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах;
- Хуулийн төслүүдэд нэмэлт санал өгөх байдлаар хууль бүтээх ажиллагаанд идэвхтэй оролцох;
- Гадаад харилцааг хөгжүүлэх буюу бусад байгууллага (Засгийн газар, шүүх болон бусад байгууллага)-тай хамтын ажиллагаагаа сайжруулах;
- Дотоод харилцааг хөгжүүлэх буюу гишүүн хуульчидтай сайн харилцаатай байх.

МХХ-ноос гишүүнчлэлийн хураамжийн хүрээнд гишүүн хуульчдад үзүүлэх үйлчилгээнүүд нь дээрх байдлаар ойлгомжтой, тодорхой байх нь зүйтэй.

1.2. МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХУУЛЬЧДЫН ОРОЛЦОО

ХЭЗБТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт зааснаар хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх барих дээд байгууллага нь Хуульчдын Их хурал байна. Монгол Улсын хувьд Хуульчдын Их хуралд нийт хуульчдаас сонгогдсон төлөөлөгчид¹⁴ оролцдог. Хуульчдын Их

¹⁴ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46.4. Хуульчдын Их хурал хуульчдын

хурлын төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг МХХ-ны дүрэм болон Их хурлын төлөөлөгч сонгох журмаар зохицуулдаг.

МХХ-ны дүрэм¹⁵-ийн 3.2 дугаар зүйлд зааснаар Хуульчдын холбооны Их хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурал нь хоёр жилд нэг удаа хуралдана, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлд зааснаар Их хурлын төлөөлөгчийн тоо нь хурал товлон зарлах шийдвэр гарах үед Хуульчдын холбоонд бүртгэлтэй байгаа нийт гишүүдийн арван хувьтай тэнцүү байдаг.

МХХ-ны их хурлын төлөөлөгч сонгох журамд¹⁶ заасны дагуу Их хурлын төлөөлөгчдийн сонгуулийг Хуульчдын холбооны сонгуульд оролцох эрхтэй хуульчдын нэрсийн жагсаалтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд үндэслэн шүүгч, өмгөөлөгч, прокурор, бусад хуульчид гэсэн төлөөллийн хэсгүүдэд хувааж хэсэг тус бүр дээр нууцаар санал хураана. Саналын дүн гарсны дараа Их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь өмгөөлөгч, 40 хувь нь шүүгч, прокурор, 20 хувь нь бусад хуульчид байхаар¹⁷ журамласан. Гэвч ХЭЗБтХ-ийн дээрх зохицуулалтыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүчингүй болсонд тооцсон. Тус хуулийн зохицуулалт хүчинтэй байх хугацаанд дөрвөн удаа Хуульчдын ээлжит их хурал¹⁸, 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр нэг удаа ээлжит бус хурал¹⁹-ыг тус тус МХХ-ноос зохион байгуулсан. Тодруулбал, Хуульчдын анхдугаар их хурлыг 2013 оны 9 дүгээр сарын 6-9-ний өдөр, 10 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд үргэлжлүүлэн зохион байгуулсан. Хурал зохион байгуулах үед

төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

¹⁵ Хуульчдын анхдугаар Их хурлын 2013.09.07-ны өдрийн хурлын 3 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монголын Хуульчдын холбооны дүрэм, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

¹⁶ МХХ-ны Зөвлөлийн хурлын тогтоол, 2015.09.05-ны өдөр, Дугаар 21.
<https://www.mglbar.mn/act/9>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

¹⁷ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46.6 дахь хэсэгт заасан бөгөөд энэ заалтыг 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр хүчингүй болсонд тооцсон.

¹⁸ <https://www.mglbar.mn/news/611>.

¹⁹ МХХ-ны Их хурлын төлөөлөгч сонгох журмын 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

бүртгэлтэй байсан 4,500 хуульчаас сонгогдсон 490 төлөөлөгч хуралд оролцжээ²⁰.

Их хурлын төлөөлөгч сонгох журамд заасны дагуу бүх гишүүн хуульч www.mglbar.mn цахим хуудас дахь өөрийн бүртгэлийн хэсэгт нэвтрэн нэрээ дэвшүүлэх, нэр дэвшсэн хуульчид санал өгөх эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Нэр дэвшүүлэх хугацааг дөрөв хоног, санал өгөх хугацааг гурав хоног байхаар тус тус тодорхойлсон. Тус журам батлагдсаны дараа буюу 2015 оны 9 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд Хуульчдын хоёрдугаар Их хурал зохион байгуулагдсан ба нийт 5,042²¹ хуульчийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулж, нэр дэвшүүлэн санал хураасны үр дүнд 535 төлөөлөгч сонгогдон, тэдгээрээс 484 төлөөлөгч хуралд оролцсон байна.²²

Сүүлд буюу 2019 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан Хуульчдын дөрөвдүгээр Их хурлын төлөөлөгчдийн тоог МХХ-ны дүрмийн дагуу 510 төлөөлөгч байхаар МХХ-ны мэдэгдэлд дурджээ²³. Сонгуулийн нэр дэвшүүлэлт, санал хураалтын үр дүнд 525 төлөөлөгч сонгогдон, тэдгээрийн 438 төлөөлөгч нь хуралд оролцсон²⁴ байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад Их хурлын төлөөлөгчдийн тоо болон оролцооны идэвх буурсан байгаа нь харагдаж байна. МХХ-ны дүрмийн дагуу нийт бүртгэлтэй хуульчийн 10 хувиар тогтоосон төлөөлөгчдийн тооноос Их хуралд сонгогдсон төлөөлөгчийн тоо олон байсан нь хэсэг тус бүрийн нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцсэний улмаас хувь тэнцүүлэн, төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх²⁵ арга хэрэглэжээ.

²⁰ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны веб хуудас.
<https://mojha.gov.mn/newmojha/?p=591>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

²¹ Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны болон захиргааны хэргийн анхан шатны шүүхийн веб хуудас.
<https://courtda.mn/main/435--.html>, сүүлд хандсан огноо: 2021.11.04.


²² МХХ-ны веб хуудас.
<https://www.mglbar.mn/news/842>, сүүлд хандсан огноо: 2021.11.08.

²³ МХХ-ны веб хуудас.
<https://www.mglbar.mn/news/3477>, сүүлд хандсан огноо: 2021.11.08.

²⁴ “Монгол Өмгөөлөгч” хууль зүйн фирмийн веб сайт.
<https://advocate.mn/news/119/single/1291>, сүүлд хандсан огноо: 2021.11.08.

²⁵ МХХ-ны Их хурлын төлөөлөгч сонгох журмын 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

Зураг 3. Хуульчдын Их хурал дахь төлөөлөл²⁶



МХХ-ны дүрэмд заасны дагуу ээлжит Их хурлын хугацааг анхдугаар Их хурал хуралдсан хугацаанаас хойш тоолохоор заасан тул 2021 ондоо багтааж уг хурлыг зохион байгуулах шаардлагатай. Ээлжит Их хурлын төлөөлөгчдийн нийт тоог холбогдох журмын дагуу тогтоох боловч тэдгээрт шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч гэсэн мэргэшлийн төлөөллийг хувиар тогтоосон хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдах үед хүчингүй болгосон. Гэсэн хэдий ч ХЭЗБТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, МХХ-ны дүрмийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Зөвлөлд мэргэшлийн төлөөллийн хувийг батлах бүрэн эрх хэвээр хадгалагдаж байна.

Дээрхээс үзвэл ХЭЗБТХ-иар МХХ-ны удирдах түвшинд шийдвэр гаргах бүрэн эрхийг гишүүд болон Зөвлөл хэрэгжүүлэх боломж олгосон нь тус холбооны хараат бус байдлыг хангасан гэж дүгнэх боломжтой байна.

²⁶ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020, 15 дахь тал.

ХЭЗБТХ-ийн төсөлд эрх барих дээд байгууллагыг өөрчлөөгүй боловч Хуульчдын Их хуралтай холбоотой дараах өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

1. Их хурал дөрвөн жилд нэг удаа хуралдана (ХЭЗБТХ-ийн төслийн 32.2 дахь хэсэг).

Хуулийн төсөл боловсруулах хүрээнд хийсэн ХЭЗБТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд “Хуульчдын холбооны бүтцийн байгууллага, эрх бүхий этгээдийн бүрэн эрхийн хугацааг тодорхой хэмжээнд уртасгах” гэсэн саналд дээрх зохицуулалт үндэслэгдсэн байна. Гэвч хугацааг уртасгах зайлшгүй шаардлагыг тодорхойлоогүй бөгөөд ХЭЗБТХ-ийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд энэ талаар дурдаагүй байна.

2. Их хурал нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчдын төлөөлөл тус бүр 40 буюу нийт 200 төлөөлөгчөөс бүрдэнэ (ХЭЗБТХ-ийн төслийн 32.3 дахь хэсэг).

Мэргэшлийн төлөөллийн тооны харьцааг ижил байхаар зохицуулах нь оновчтой зохицуулалт эсэх нь эргэлзээтэй. Учир нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХХ-нд бүртгэлтэй нийт 5,853 хуульч байгаагаас шүүгч 535, прокурор 522, өмгөөлөгч 2,615, бусад нь 2,181 байна.²⁷ Тодруулбал, өмгөөлөгч болон бусад хуульчид хамаарах гишүүд шүүгч болон прокуророос 4-5 дахин их, мөн нотариатч хуульчийн тоо тодорхойгүй байна. Холбооны гишүүн бүрийн санал өгөх, төлөөлөгчөөрөө дамжуулан Их хуралд оролцох эрхийг хангах зорилгоор мэргэшлийн төлөөлөл тус бүрийг хувь тэнцүүлэн ялгамжтай тогтоох нь гишүүн бүрийн оролцоог хангахад чухал ач холбогдолтой. Мөн Их хурлын төлөөлөгчдийн тоог хуулиар бус Хуульчдын холбооны дүрмээр тодорхойлох олон улсын туршлагауд түгээмэл байдаг бөгөөд энэ нь хараат бус, бие даасан өөрийн удирдлагыг хэрэгжүүлж буйн нэг жишээ болж байна.

Их хурлын төлөөлөгч томилох үед ХЭЗБТХ-ийн төслийн 32.5-д “...Их хуралд оролцох шүүгчийн төлөөлөл хүрэлцэхгүй тохиолдолд

²⁷ Хуульчдын нэгдсэн тоо, статистик мэдээлэл, МХХ-ны веб хуудас. <https://www.mglbar.mn/content/35>.

...бусад гишүүдийн төлөөллөөс бүрдүүлнэ” гэсэн нь бүх шүүгч эрхээ түдгэлзүүлэх тохиолдолд эрсдэл үүсэхээр байна. Учир нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго болох шударга ёс, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, ёс зүйн болон үйлчилгээний өндөр стандарт тогтоох зэрэгт шүүгчдийн оролцоо чухал байр суурь эзэлнэ. Тиймээс МХХ-ны дээд удирдлагыг хэрэгжүүлэх Их хуралд төлөөллөө оролцуулах шүүгчдийн эрх ашгийг анхаарч, зохих түвшинд хангах шаардлагатай.

3. Их хурлын шүүгч, прокурор, бусад хуульчийн төлөөллийг МХХ, өмгөөлөгч болон нотариатын төлөөллийг МӨХ, Монголын Нотариатчдын танхим тус тус хариуцан сонгон шалгаруулна (ХЭЗБтХ-ийн төслийн 32.4 дэх хэсэг).

МХХ-ны Их хурлын төлөөлөгчдийг сонгох журмын дагуу шүүгч, прокурор, өмгөөлөгч болон бусад хуульч гэсэн дөрвөн бүлгийн төлөөллийн хэсэгт бүртгэлтэй нийт гишүүдийг хувааж, төлөөлөгчийн сонгуульд нэр дэвшүүлж, санал өгнө. Тус тусдаа мэргэшлийн холбоодоос Их хурлын төлөөлөгчийг сонгох тохиолдолд төлөөлөгчдөд тавигдах нэгдсэн шалгуурыг тодорхойлох шаардлага үүснэ. Тиймээс энэ зохицуулалттай холбоотойгоор Их хурлын төлөөлөгчдөд тавигдах нэгдсэн шаардлагыг МХХ-ны дүрмээр тодорхойлох нь зүйтэй.

1.3. МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ УДИРДЛАГЫГ СОНГОХОД АНХААРАХ АСУУДАЛ

ХЭЗБтХ-д зааснаар МХХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага нь Зөвлөл байна. Зөвлөл нь ХЭЗБтХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар гучаас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба дараах төлөөллөөс бүрдэхээр хуульд заасан. Үүнд:

- Эрх зүйн салбар, мэргэшил болон тусгай асуудлаар хорооны гишүүд сайн дураараа байгуулсан батламжилсан хороодын төлөөлөл (хороо тус бүрээс дөрөв хүртэлх);
- Хууль зүйн сургуулийн оюутны төлөөлөл нэг;

- Хуульчийн шалгалт өгөхөөр мэргэжлийн дадлага хийж байгаа эрх зүйчдийн төлөөлөл нэг.

МХХ-ны дүрэмд²⁸ зааснаар эрх зүйн салбарын чиглэлээр: үндсэн хуулийн, олон улсын, захиргааны, иргэний, эрүүгийн, эдийн засгийн эрх зүйн гэсэн зургаан салбар хороо; мэргэшлийн чиглэлээр: шүүгчдийн, прокурорын, өмгөөлөгчдийн гэсэн гурван хороо; тусгай асуудлын чиглэлээр: нийтийн тусын тулд болон төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх хоёр хороо гэсэн сайн дурын нийт 11 хороотой байна. Эдгээр хороо нь гишүүдийн тооноос хамаарч дөрөв хүртэлх төлөөлөгчийг сонгон, Зөвлөлд оруулна. Тодруулбал, ХЭЗБТХ-ийн 49.8-д зааснаар хорооны гишүүний тоо 50 ба түүнээс дээш бол хоёр, 100 ба түүнээс дээш бол гурав, 200 ба түүнээс дээш бол дөрвөн гишүүнийг тус бүр төлөөлөгчөөр сонгоно. Үүний дагуу 2020 онд МХХ-ны зөвлөл 48 гишүүний бүрэлдэхүүнтэй²⁹ байсан.

Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно. Хууль зүйн сургуулийн оюутны төлөөлөл, эрх зүйчдийн төлөөллөөс сонгогдсон зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг нэг жил байхаар заасан. Зөвлөл нь МХХ-ны ажлын төлөвлөгөөг хэлэлцэх, дүрэм, журмыг батлах, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хэлэлцэх, Тамгын газар, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, төсөв, үйл ажиллагааны санхүүгийн тайланг хэлэлцэж батлах, салбар, нэгж байгуулах, татан буулгах зэрэг ХЭЗБТХ болон МХХ-ны дүрэмд заасанаар өргөн хүрээтэй бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Гэтэл хороодыг төлөөлөн Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх журам хэт ерөнхий буюу сонгуулийг товлох, нэр дэвшүүлэх хугацаа, нэр дэвшигчид тавигдах тусгайлсан шаардлага болон сонгогдсон төлөөлөгчийн үйл ажиллагааг хороод хэрхэн хянахтай холбоотой заалтыг хууль, дүрэмд нарийвчлан заагаагүй. Нөгөөтээгүүр Зөвлөлийн гишүүнийг сонгох сонгуулийн дүнг тоолох буюу сонгуулийн үр дүн үнэн зөв гарч байгаа эсэхэд хяналт тавих тооллогын комиссын гишүүн эсхүл

²⁸ МХХ-ны дүрмийн 8.10, 8.11, 8.12 дугаар зүйл.

²⁹ Монголын Хуульчдын холбооны веб хуудас.

<https://www.mglbar.mn/news/3839>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

хяналтын ажилтныг тухайлан томилдоггүй, энэ талаарх зохицуулалт хууль, дүрэмд тусгагдаагүй байна.

ХЭЗБтХ-ийн төсөлд³⁰ “Удирдах зөвлөл шүүгч, прокурор, өмгөөлөл, нотариат болон бусад хуульчдын төлөөллөөс бүрдэнэ” гэж өөрчилсөн ба гишүүнд нэр дэвшүүлэх журмыг МХХ-ны дүрмээр зохицуулахаар тусгажээ. Энэ нь дээр дурдсан Зөвлөлийн гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэхтэй холбоотой хууль, дүрмээр зохицуулагдаагүй байгаа асуудлыг шийдвэрлээгүй ч дүрмээр зохицуулахаар нээлттэй үлдээсэн байна. Мөн Зөвлөлийн гишүүдийн тоог бууруулж, “Удирдах зөвлөл 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба дөрвөн жилийн хугацаагаар сонгогдоно” гэж өөрчилсөн нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчийн төлөөлөл тус бүр тав байхаар байна. Хуульчдын нэгдсэн бүртгэлд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 535 шүүгч, 522 прокурор, 2615 өмгөөлөгч, 2181 бусад хуульч бүртгэлтэй³¹ байна. Ийнхүү хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчийн тоо харилцан адилгүй байхад тэнцүү тооны төлөөлөл байхаар хуулийн төсөлд тусгасан нь сонгогдсон төлөөлөгчид бусад хуульчдын эрх, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлж, төлөөлж чадах эсэхэд эргэлзээ үүсгэж байна. Иймд Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход бүх хуульчдын оролцоог хангах, Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагааг хүртээмжтэй, шударгаар явуулахад чиглэсэн заалтуудыг МХХ-ны дүрэмд нарийвчлан тусгах шаардлагатай.

МХХ-ны Ерөнхийлөгчийг ХЭЗБтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2.3-т зааснаар Хуульчдын Их хурлаас сонгоно. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд түүнийг улируулан сонгохгүй байхаар заасныг ХЭЗБтХ-ийн төсөлд “Ерөнхийлөгчийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох бөгөөд улируулан сонгохгүй” гэж өөрчилсөн. Ийнхүү өөрчлөх үндэслэлээ Холбооны бодлого, журмын хэрэгжилт үр нөлөөтэй, тогтвортой, уялдаа холбоотой хэрэгжих

³⁰ УИХ-д 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
<http://forum.parliament.mn/projects/11102>.

³¹ Монголын Хуульчдын холбооны веб хуудас, Хуульчдын нэгдсэн тоо, статистик мэдээлэл, сүүлд хандсан огноо: 2021.11.07.

боломж муу, гишүүдийн сар бүр төлдөг хураамжид үндэслэдэг Холбооны хөрөнгийг үргүй зарцуулах нөхцөл бий болгож байсныг өөрчлөх зорилготой гэж тайлбарлажээ.

Гэтэл ХЭЗБтХ, МХХ-ны дүрэмд зааснаар Ерөнхийлөгчид аливаа дүрэм, журам батлах, Холбооны хөрөнгийн зарцуулалтад оролцох бүрэн эрх олгогдоогүй. Харин ХЭЗБтХ-ийн төсөлд зааснаар Ерөнхийлөгч Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох шийдвэр гаргах, Удирдах зөвлөлийн хуралд саналын эрхтэй оролцох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.

ХЭЗБтХ-ийн төсөлд Ерөнхийлөгчөөр сонгогдох хугацааг уртасгаснаас Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан заалтууд тусгагдаагүй байна.

ХОЁР. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ГИШҮҮНЧЛЭЛ

Энэхүү судалгааны хүрээнд АНУ, Австрали Улс, Япон Улс болон постсоциалист орнууд дахь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага буюу “*Bar Association*”-ийн хууль эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах замаар бусдаасаа ялгаатай онцлог шинжүүдийг гаргахыг зорьсны дээр гишүүнчлэлийн төрлийг мөн авч үзсэн болно.

Хүснэгт 1. Хуульчдын холбооны онцлог (хуулийн этгээдийн хэлбэр, гишүүнчлэлээр)

Улсууд	Байгууллагын нэр	Хуулийн этгээдийн хэлбэр	Хууль зүйн зохицуулалт (Зөвхөн үндсэн эх сурвалжийг дурдав)	Гишүүнчлэл
АНУ	Америкийн Хуульчдын холбоо (<i>American Bar Association</i>)	Сайн дурын нэгдэл	Америкийн Хуульчдын холбооны дүрэм ³²	Сайн дурын
	Нью Йорк муж улсын Хуульчдын холбоо (<i>The New York State Bar Association</i>)	Сайн дурын нэгдэл	Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны дүрэм	Сайн дурын

³² АНУ-ын Хуульчдын холбооны дүрэм, Constitution and Bylaws, rule of procedure house of delegates.
<https://www.americanbar.org/2020-2021-constitution-and-bylaws.pdf>, сүүлд хандсан огноо: 2021.10.25.

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Австрали Улс	Австрали Улсын Хуульчдын холбоо (<i>Australian Bar Association</i>)	Корпорацын тухай хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд	Австрали Улсын Хуульчдын холбооны дүрэм	Заавал
	Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэг (<i>New South Wales Law Society</i>)	Баталгаат хязгаарлагд- мал нээлттэй компани	Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгийн дүрэм	Сайн дурын
Япон Улс	Япон Улсын Хуульчдын холбоо (<i>Japan Federation of Bar Associations</i>)	Өмгөөллийн тухай хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд	Япон Улсын Хуульчдын холбооны дүрэм	Заавал
Постсоциалист орнууд	Оросын Хуульчдын холбоо (<i>Ассоциация юристов в России</i>)	Олон нийтийн нэгдэл	Оросын Хуульчдын холбооны дүрэм	Сайн дурын
	Литва Улсын Хуульчдын холбоо (<i>Lithuanian Bar Association</i>)	Хуульчдын холбооны хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд	Хуульчдын холбооны тухай хууль	Заавал
	Бүгд Найрамдах Беларусь Улсын Хуульчдын зөвлөл (<i>Белорусский Республиканский союз юристов</i>)	Олон нийтийн нэгдэл	Беларусийн Хуульчдын зөвлөлийн дүрэм болон бусад хууль тогтоомж	Сайн дурын

Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага нь хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд, олон нийтийн нэгдэл, компани гэсэн хуулийн этгээдийн хэлбэрээр, хуулиар эсхүл гишүүдийн сайн дурын нэгдэл болж үүсгэн байгуулагддаг. Гишүүнчлэлийн хувьд сайн дурын болон заавал гэсэн үндсэн хоёр төрөлтэй байна. Тухайлбал, АНУ, ОХУ, Беларусь Улсын Хуульчдын холбоо нь сайн дурын гишүүнчлэлтэй, сайн дурын нэгдэл байдаг бол Япон, Литва улсуудын Хуульчдын холбоо нь заавал гишүүнчлэлтэй, хуулийн этгээд, харин Австрали Улсын Хуульчдын нийгэмлэг нь сайн дурын гишүүнчлэлтэй, нээлттэй компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байна. Монгол Улсын хувьд Хуульчдын холбоо нь ХЭЗБтХ-ийн дагуу үүсгэн байгуулагдаж, заавал гишүүнчлэлтэй нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүснэгт 2. Хуульчдын холбооны онцлог (гишүүнчлэлийн төрлөөр)

Улс орнууд	Гишүүнчлэлийн төрөл	Гишүүнээр элсэх, гишүүнчлэл дуусгавар болгох зохицуулалтын зарим онцлог
АНУ	АНУ-ын Хуульчдын холбооны гишүүд; ³³ - Хуульч - Хуулийн сургуулийн оюутан - Бусад мэргэжилтэн	- Холбооны дүрэмд заасны дагуу ³⁴ аль нэг муж улс, нутаг дэвсгэр, холбооны шүүхээс хүлээн зөвшөөрсөн АНУ-ын хуульчдын аль нэг холбоонд харьяалагддаг, ёс суртахуун, зан чанарын хувьд сайн хүн Холбооны гишүүнээр элсэж болно. ³⁵ - Хуулийн сургуулийн оюутан, олон улсын хуульчид гишүүнээр элсэх боломжтой ч үндсэн гишүүнээс ялгаатай эрх, үүрэг хүлээнэ. ³⁶ - Гишүүн өөрөө Холбооны гишүүнчлэлээс гарах хүсэлт гаргасан, дүрмийн дагуу гишүүний хувьд төлөх ёстой мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлээгүй, хүнд гэмт хэрэгт шийтгэгдэх шүүхийн эцсийн шийдвэр гарсан, аль нэг улсад хуулийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь зургаан сар, түүнээс дээш хугацаагаар түдгэлзүүлсэн, хассан зэрэг үндэслэлээр Холбооны гишүүнчлэл дуусгавар болно. ³⁷

³³ Гишүүнчлэлийн дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас үзнэ үү.

³⁴ Холбоонд гишүүнээр элсэх өргөдлийг АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 21.1-т заасны дагуу Холбооны Удирдах зөвлөлөөс баталсан загвар маягтын дагуу гаргана.

³⁵ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 3 дугаар зүйл.

³⁶ *Ibid.*

³⁷ *Ibid.*

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны гишүүд ³⁸ ;	- АНУ-ын нутаг дэвсгэрт үл хамаарах газар өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд гишүүнээр элсэх боломжгүй.
- Идэвхтэй гишүүн ³⁹	
- Хамтрагч гишүүн ⁴⁰	
- Хүндэт гишүүн ⁴¹	
- Хуулийн оюутан ⁴²	
- Дэмжлэгтэй гишүүн ⁴³	

³⁸ Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны дүрмийн 3 дугаар зүйл. https://nysba.org/NYSBA/Advocacy/ENABLING_ACT
³⁹ *Идэвхтэй гишүүн* гэдэгт Нью Йорк муж улсад хууль зүйн мэргэжлийн чанартай үйлчилгээ үзүүлж, түүнийг нотлох баримт болон маягтуудыг гаргаж өгсөн гишүүнийг ойлгоно. Холбогдох баримтыг Холбоонд гарган өгч, гишүүний хураамж төлснөөр гишүүний эдлэх эрх, үүргийг шууд хэрэгжүүлэх боломжтой болно.

⁴⁰ *Хамтрагч гишүүн* гэдэгт АНУ-ын Нью Йорк муж улсаас бусад муж улс, нутаг дэвсгэрт хууль зүйн мэргэжлийн чанартай үйлчилгээ үзүүлж, түүнийг нотлох баримт болон маягтуудыг гаргаж өгсөн гишүүнийг ойлгоно. Холбогдох баримтыг Холбоонд гарган өгч, гишүүний хураамж төлөх бөгөөд Холбооны салбарын удирдлага болон Удирдлагын хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд Холбооны салбарын дарга, Удирдлагын хороо эсхүл Төлөөлөгчдийн танхимын гишүүн байхаас бусад гишүүний эдлэх эрх, үүргийг шууд хэрэгжүүлэх боломжтой болно.

⁴¹ *Хүндэт гишүүнийг* тухайн Холбооноос сонгоно.

⁴² *Хуулийн оюутан гишүүн* гэдэгт хуулийн чанартай сургуульд суралцаж буй аливаа оюутан байж болох бөгөөд шаардлагад тохиолдолд сурч буй сургууль нь дээрх шаардлагад нийцэж буйг болон Давж заалдах шатны шүүхийн дүрмийн дагуу баталгаажсан хуулийн сургууль болохыг нотолсон баримт, тухайн жилийн гишүүний хураамжийг төлсөн баримтыг бичгээр гаргасан хүсэлтийн хамт шаардана. Хуулийн оюутан сургуулиа төгссөн, АНУ-ын цэргийн албанд татагдсан эсхүл хуулийн сургуульд суралцахгүй болсон зэрэг тохиолдолд тухайн хуанлийн жилээр эцэслэн түүний гишүүнчлэл дуусгавар болно. Хуулийн оюутан Холбооны салбарын эсхүл Хорооны дарга, Удирдлагын хороо, Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Холбооны албан тушаалтанд нэр дэвших, тэдгээрт санал өгөхөөс бусад идэвхтэй гишүүний эрх эдэлнэ. Хуулийн оюутан сургуулиа төгссөнөөс хойш сөн сарын дотор шаардлагад баримтыг бүрдүүлж идэвхтэй эсхүл хамтрагч гишүүн болох боломжтой.

⁴³ *Дэмжлэгтэй гишүүнийг* Төлөөлөгчдийн танхимаас тодорхойлох ба гишүүнчлэлийн төлбөрийн хэмжээг өөрчлөх, төлбөр хүлээн авахтай холбогдох журам баталж хэрэгжүүлэх бүрэн эрхтэй.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Австрали Улс	Австрали Улсын Хуульчдын холбооны гишүүд: - Муж, бүс нутгийн Хуульчдын холбоо - Бие даасан гишүүн	- Муж, бүс нутгийн Хуульчдын холбоод заавал гишүүн байна. Үүнд: Шинэ Өмнөд Уэльс, Квинслэнд, Өмнөд Австрали, Баруун Австрали, Австралийн нийслэлийн бүс нутгийн, Хойд бүс нутгийн, Тасманийн нийт найман Хуульчдын холбоо хамаарна. - Мэргэжлээрээ ажиллаж буй барристер, насан туршийн гишүүн (<i>life members</i>) болон хүндэт гишүүн бие даасан гишүүнээр элсдэг. Насан туршийн болон хүндэт гишүүдийг Хуульчдын холбооны Зөвлөлөөс тодорхойлж, томилдог.
Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн гишүүд ⁴⁴ : - Солиситор гишүүд ⁴⁵ - Хамтрагч гишүүд - Оюутан гишүүд - Насан туршийн гишүүд - Хүндэт гишүүд - Хуулийн фирмийн гишүүд ⁴⁶ - Зөвлөлөөс тодорхойлсон бусад гишүүд	- Гишүүд нь хамаарах гишүүнчлэлийн төрлийг сонгож, Зөвлөлөөс тогтоосон маягтын дагуу гишүүнчлэлийн хүсэлт гарган, жилийн хураамжаа төлснөөр гишүүний бүртгэлд бүртгүүлнэ. - Гишүүнчлэлийн хураамжийг санхүүгийн жил эхлэх өдөр төлөх ба хэрэв санхүүгийн жил эхэлснээс хойш гишүүнээр элссэн тохиолдолд гишүүнээр элссэн өдөртөө төлөөгүй нь гишүүний бүртгэлээс хасагдах үндэслэл болно. - Хуульчдын нийгэмлэгийн гишүүнчлэлээс гарах хүсэлтээ бичгээр гаргасан, гишүүн нас барсан, гишүүнчлэлийн хураамжийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд гишүүнчлэлийг автомагаар хүчингүй болгох ба дүрэмд заасан үндэслэлээр Зөвлөлөөс тухайн эгтээдийг нийгэмлэгийн гишүүнчлэлтэй байхад тохиромжгүй гэж үзсэн тохиолдолд гишүүнчлэлийг Зөвлөлийн шийдвэрээр дуусгавар болгоно. - Хуулийн фирмийн гишүүдийн гишүүнчлэл нь уг фирм үйл ажиллагаа явуулахаа больсон, бүртгэлээс хасагдсан, Корпорацийн тухай хуульд заасны дагуу таган буутдсан тохиолдолд гишүүнчлэлийг хүчингүй болгоно.	
<p>⁴⁴ Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгийн дүрмийн 6.1 дүгээр зүйл. https://www.lawsociety.com.au/NSW Constitution</p> <p>⁴⁵ Солиситор нь Хуульчдын нийгэмлэгийн гишүүн байх ба өөрийн муж улсын Хуульчдын нийгэмлэгт заавал гишүүнчлэлтэй байх ёстой байсныг 2002 онд өөрчилж, хуульчид сайн дураараа Хуульчдын нийгэмлэгийн гишүүн болохоор өөрчилсөн.</p> <p>⁴⁶ Хуулийн фирм (Incorporated Legal Practice) нь Корпорацийн хуульд зааснаар компанийн хэлбэртэй байх бөгөөд корпораци болон бусад хуулийн этгээдэд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчид нь Австралид хуулийн чиглэлээр ажиллаж буй хуульчдаар хязгаарлагдахгүйгээр үйлчилгээ үзүүлдэг.</p>		

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Ягц ноц	<p>Япон Улсын Хуульчдын холбооны гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Өмгөөлөгч⁴⁷ - Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани⁴⁸ - Бүртгэлтэй гадаад хуульч⁴⁹ - Бусад гишүүн 	<ul style="list-style-type: none"> - Өмгөөлөгчид, хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд болон бүртгэлтэй гадаадын хуульчид орон нутгийн Хуульчдын холбоо⁵⁰-нд бүртгүүлэх үед Япон Улсын Хуульчдын холбоонд зэрэг бүртгүүлдэг.
---------	---	--

⁴⁷ *Өмгөөлөгч* гэдэгт өөрийн сонгосон орон нутгийн хуульчдын холбоо болон Хуульчдын холбоонд гишүүнээр бүртгүүлсэн хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг ойлгоно.

⁴⁸ *Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани* нь 2002 оны 4 дүгээр сараас хойш буюу өмгөөлөгчдийг хууль зүйн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий хууль зүйн мэргэжлийн компани байгуулахыг хуулиар зөвшөөрсөн үеэс үүссэн. Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани нь үүстэн байгуулагдсан үеэс Хуульчдын холбоо болон харьяа дүүргийн орон нутгийн Хуульчдын холбооны гишүүн болно.

⁴⁹ *Бүртгэлтэй гадаад хуульч* гэдэгт Япон Улсаас бусад улс, нутаг дэвсгэрт хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Япон Улсад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан хуульчдыг ойлгоно. Эдгээр хуульчийг Хууль зүйн яамны сайдаар баталгаажуулсан Хуульчдын холбооны гадаад хуульчдын жагсаалтад нэрээ хадгалахыг шаарддаг.

⁵⁰ Япон Улс орон нутгийн нийт 52 холбоотой бөгөөд эдгээр нь Токиогоос гадна 50 дүүрэг тус бүрд нэг байдаг, мөн Өмгөөлөгчийн тухай хуулийн дагуу байгуулагдах Хуульчдын холбоо гурав бий. Хуульчдын эдгээр холбооны гишүүд нь өмгөөлөгч, хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани, бүртгэлтэй гадаадын хуульчид байна.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Постсоциалист орнууд	ОХУ-ын Хуульчдын холбооны гишүүд: - Хууль зүйн дээд боловсролтой, 18 насанд хүрсэн ОХУ-ын иргэн ⁵¹	- Гишүүнээр элсэх хүсэлтээ Холбоонд гаргах бөгөөд тухайн бүсийн Гүйцэтгэх хорооны (Исполнительный комитет) шийдвэрээр эсхүл Холбооны удирдах байгууллагын гишүүдийн олонхын саналаар эсхүл бүсийн Холбооны Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр гишүүнээр элсүүлнэ. - Хууль зүйн дээд боловсролтой гишүүдээс гадна байгууллагын үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах зорилгоор хүндэт гишүүдийг холбоонд элсүүлдэг онцлогтой.
		- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн эсхүл шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон иргэн болон ОХУ-ын хууль тогтоомжоор олон нийтийн байгууллагын гишүүн байхыг хориглосон этгээд Холбооны гишүүн байх эрхгүй. - Холбооноос гишүүнчлэлийн эрхийг дараах тохиолдолд хүчингүй болгодог. Үүнд: - Холбооны дүрэм болон бусад хэм хэмжээний актад заасан ноцгой зөрчил эсхүл давтан зөрчил гаргасан; - Холбооны гишүүний үүргийг биелүүлээгүй; - Холбооны үйл ажиллагааг доромжилсон үйлдэл гаргасан; - Иргэн нас барсан.

⁵¹ Устав общероссийской общественной организации “Ассоциация юристов России”.
<https://alrf.ru/upload>

Хүснэгт 2-ын үргэлжлэл

<p>Литва Улсын Хуульчдын холбооны гишүүд⁵².</p> <ul style="list-style-type: none"> - Өмгөөлөгч - Өмгөөлөгчийн туслах 	<ul style="list-style-type: none"> - Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуульч Холбоонд хүсэлт гаргасны үндсэн дээр гишүүнээр элсэх эрхтэй. - Өмгөөлөгч нас барсан, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх бүрэн эрх дуусгавар болох хуульд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд гишүүнчлэл дуусгавар болно.
<p>Беларусь Улсын Хуульчдын нэгдсэн зөвлөлийн гишүүд⁵³:</p> <ul style="list-style-type: none"> - 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, хууль зүйн дээд боловсролтой Беларусь Улсын иргэн, Беларусь Улсад байнга оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүн 	<ul style="list-style-type: none"> - Удирдах зөвлөлийн эсхүл хууль, дүрэмд заасан эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэрээр элсүүлнэ. - Хуульч нас барсан, зөрчил гаргасан болон бусад үндэслэлээр гишүүнчлэлийг дуусгавар болгоно.

⁵² Republic of Lithuania Law on the Bar. IX-2066 Law on the Bar

⁵³ Устав общественного объединения “Белорусский Республиканский союз юристов”. <https://union.by>, Устав - Союз юристов Беларуси

Гадаад улсууд дахь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын гишүүнчлэлийн онцлогтой холбоотойгоор “*Bar Association*” нэр томъёог ялгаатай орчуулж, тайлбарлах эсэх асуудал судлаачдын багийн өмнө үүссэн. Тухайлбал, АНУ-ын Хуульчдын холбоо, Австралийн муж улсын Хуульчдын нийгэмлэг зэрэгт бүх хуульч; ОХУ, Беларусь Улсад хуульчдаас гадна эрх зүйчид, Австрали, Япон, Литва улсуудад өмгөөлөгчид нь мэргэжлийн холбоонд гишүүнээр элсдэг онцлогтой.⁵⁴ Харьцуулалтын нэг элемент болох холбооны гишүүнчлэлийн онцлогт үндэслэн “*Bar Association*” гэж албан ёсоор томъёологдсон нэр томъёог хоёр болон түүнээс дээш утгаар тайлбарлаж, орчуулан хэрэглэх нь зохимжгүй буюу ойлгомжгүй байдал үүсгэх тул “Хуульчдын холбоо” гэсэн нэгдсэн ойлголтоор судалгаанд хэрэглэсэн болно.

Харьцуулан судалж буй улсуудаас АНУ, Австрали, Япон улсуудад хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага харьцангуй өндөр хөгжин, сайн туршлага хэрэгжүүлж байна. Дээрх улс орнуудад Хуульчдын холбооны гишүүний оролцоо, идэвх, эрхэлж буй хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, гишүүдийн эдлэх эрх, төлөх хураамжийн хэмжээнээс хамаарч гишүүдийг дотор нь төрөлжүүлдэг. Гишүүнчлэлийн төрлөөс хамаарч зарим гишүүнд ээлжит хуралд оролцох, санал өгөх, Зөвлөл, Ерөнхийлөгч, сонгогддог бусад албан тушаалд нэр дэвших, тэдгээрийг сонгох эрхтэй бол зарим гишүүд эдгээр эрхийг эдэлдэггүй тул гишүүнчлэлийг төрөлжүүлэх байдлаар гишүүдийн идэвх, оролцоо, санал санаачилгыг нэмэгдүүлж байна. Харин МХХ нь гишүүнчлэлийг төрөлжүүлж, түүнд үндэслэн гишүүний эдлэх эрх, хүлээх үүрэг, хураамжийг ялгаатай байдлаар тогтоогоогүй. Иймээс МХХ-ны үйл ажиллагаанд гишүүдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, шинэ санал, санаачилга гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дээрх сайн туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Харьцуулан судалсан улсуудын хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын онцлогийг нэгтгэн Хүснэгт 1, 2-т харуулснаас гадна бусад онцлогийг улс бүрээр тодруулан авч үзье.

⁵⁴ Тодорхой гишүүнчлэлийн төрлийг Хүснэгт 2-оос үзнэ үү.

2.1.1. АНУ-ын Хуульчдын холбоо

АНУ-ын Хуульчдын холбоо⁵⁵ нь 1878 онд АНУ даяар хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, хууль зүйн мэргэжилтэн, хуулийн сургуулиудыг магадлан итгэмжлэх, жишиг ёс зүйн кодекс болон эдгээрт холбогдох бусад асуудалд зориулсан арга хэмжээ авах зорилгоор үүсгэн байгуулагдсан түүхтэй.

Тус Холбоо нь АНУ-ын Үндсэн хууль болон ардчилсан төлөөллийн засаглалыг хадгалж хамгаалах, эрх зүйн системийн мэдлэгийг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэр болон хуулийг нэг мөр дагаж мөрдөх, шударга ёсны хэрэгжилтийг муж бүрд дээшлүүлэх, нийтийн сайн сайханд мэргэжлийн үйл ажиллагаа, мэдлэгээр дэмжлэг үзүүлэх, гишүүдийн нөхөрсөг хамтын ажиллагааг дэмжих зорилгыг хэрэгжүүлэх бөгөөд эдгээр зорилгыг мэргэжлийн болон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн мужуудын хуульчдын өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллахад чиглэнэ гэж тодорхойлсон.⁵⁶ Холбоонд гишүүнээр элссэн тохиолдолд хуульчийн 600 гаруй төрлийн мэргэжлийн үргэлжилсэн багц сургалтад үнэ төлбөргүй хамрагдах, хууль зүйн практикт ашиглагдаж буй контент, сүлжээ, техникүүдийн эх сурвалжтай танилцах, мэргэшиж буй салбар эрх зүйн мэдлэг, туршлага солилцох гишүүдийн байгуулсан нэгдэлд оролцох, Холбооны карьер сургалтын төвөөр дамжуулан карьераа хэрхэн өсгөх, мэргэжлийн болон танилын цар хүрээгээ тэлэх зэрэг олон боломжоос хүртэнэ.⁵⁷ Гишүүнчлэлийн жилийн хураамжийн төрөл болон хэмжээг Хүснэгт 3-т харуулав.

⁵⁵ American Bar Association.

https://www.americanbar.org/about_the_aba/, сүүлд хандсан огноо: 2021.10.25.

⁵⁶ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 1.2 дугаар зүйл.

⁵⁷ АНУ-ын Хуульчдын холбооны веб хуудас.

<https://www.americanbar.org/membership/>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

Хүснэгт 3. АНУ-ын Хуульчдын холбооны гишүүнчлэлийн жилийн хураамж

	Гишүүнчлэл	Жилийн хураамж (ам.доллар)
	Хуульч	75-450*
	Засгийн газарт ажиллаж буй хуульч	150
	Ашгийн төлөө бус/Нийтийн эрх ашгийн хуульч	150
	Шүүгч	150
Хуульчид	Хууль зүйн мэргэжлийн ганцаарчилсан үйл ажиллагаа эрхлэгч	150
	Хоёроос таван ажилтантай жижиг хуулийн фирмийн хуульч	150
	Тэтгэвэрт гарсан эсхүл идэвхгүй хуульч	150
Хуулийн оюутан	Хууль зүйн сургуулийн оюутан	0
	Хуулийн оюутны онцгой гишүүнчлэл	25
	Хууль зүйн сургуулийн бус оюутан	0
Бусад мэргэжилтэн	Эрх зүйч	75
	Бусад салбарын мэргэжилтэн	150
	Олон улсын хуульч	150
	Төгсөх курсийн оюутан, шинэ төгсөгч, Барын шалгалтын бүртгүүлэгч	75

* Үнийн дүнг гишүүнчлэлийн жилээс хамаарч тогтооно.

АНУ-ын муж улс бүр Хуульчдын холбоотой тул муж улсын хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын онцлог шинжийг судлах зорилгоор хамгийн олон гишүүнтэй⁵⁸ Нью Йорк муж улсын Хуульчдын холбоог сонгосон болно.

*Нью Йорк муж улсын Хуульчдын холбоо*⁵⁹ нь 1876 онд хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрх зүйн шинэчлэлийг дэмжих, шударга ёсны хэрэгжилтийг хангах, хууль зүйн мэргэжлийн нэр хүнд, ур чадвар, ёс зүй, үнэнч байдлын стандартыг өсгөх, гишүүдийн найрсаг хамтын ажиллагааг хамгаалж сайжруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд одоог хүртэл энэ зорилгыг баримталдаг.⁶⁰ Нью Йорк муж улсын Хуульчдын холбоог албан ёсоор 1877 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Нью Йорк муж улсын Сенатын танхимаас баталсан “Нью Йорк муж улсын Хуульчдын холбоо байгуулах акт”⁶¹-д үндэслэн байгуулсан бөгөөд тухайн эрх зүйн актын хүрээнд Холбооны үйл ажиллагааг зохицуулах дүрэм баталсан. Гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээг жил бүр Төлөөлөгчдийн танхимаас шинэчлэн тогтоох бөгөөд санхүүгийн жилийн эхэнд гишүүд төлсөн байх үүрэг хүлээнэ. Хураамжийн хэмжээг тогтооход Холбооны Санхүүгийн болон Удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу дараагийн жил мөрдөгдөх гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг урьдчилан тогтоох эрхтэй бөгөөд шинэ гишүүн өөрчлөгдсөн хураамжийг төлнө.

Хүснэгт 3-т дурдсан гишүүнчлэлийн төрлүүдэд хамаарахгүй “Өмгөөлөгч биш хүсэлт гаргагч”⁶² гэх статусыг мөн Холбооны дүрэмд тодорхойлсон. Хууль зүйн мэргэжлийн дипломтой боловч мэргэжлээрээ АНУ-ын аль нэг муж улс, нутаг дэвсгэрт ажиллаагүй, Давж заалдах шатны шүүхийн дүрмийн дагуу баталгаажсан хууль зүйн сургуульд ажилладаг эсхүл

⁵⁸ Нью Йорк муж улсын нийт хуульчийн тоо 2019 оны байдлаар 184,662 байна. АНУ-ын Хуульчдын холбооноос хийсэн Хууль зүйн мэргэжлийн нөхцөл байдал (ABA Profile of the Legal Profession)-ын судалгаа, 2020, 3 дахь тал.
<https://www.americanbar.org> ABA Profile of the Legal Profession, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

⁵⁹ The New York State Bar Association.

⁶⁰ Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны веб хуудас.
<https://nysba.org/about/>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

⁶¹ An Act to incorporate the New York State Bar Association.
https://nysba.org/NYSBA/Advocacy/ENABLING_ACT

⁶² Non-attorney Affiliate.

аль нэг Хуульчдын холбоонд ажилладаг эсхүл хуульчийн туслах, эрх зүйч, хуулийн фирм, компани, Засгийн газрын байгууллага болон бусад хуулийн этгээдэд хууль зүйн чиглэлээр ажилладаг хүнийг энэ статуст хамааруулна. Өмгөөлөгч биш хүсэлт гаргагч нь гишүүний статуст хамаарахгүй бөгөөд гишүүнчлэл авахад шаардлагатай баримтуудыг бүрдүүлж өгснөөр Холбооны эсхүл салбар хорооны дарга, Удирдлагын хороо эсхүл Төлөөлөгчдийн танхимын гишүүн, тэдгээрт санал өгөхөөс бусад бүх гишүүний эдлэх эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжтой.

2.1.2. Австрали Улсын Хуульчдын холбоо болон Хуульчдын нийгэмлэг

Австрали Улсад Хуульчдын холбоо (*Bar Association*) болон Хуульчдын нийгэмлэг (*Law Society*) зэрэгцэн үйл ажиллагаа явуулдаг. Австрали Улс нь Шинэ Өмнөд Уэльс, Квинслэнд, Өмнөд Австрали, Тасмани, Викториа, Баруун Австрали гэсэн зургаан муж улс, Австрали Улсын Нийслэлийн бүс нутаг болон Хойд бүс нутаг гэсэн засаг захиргааны хоёр нэгжтэй бөгөөд муж улс, бүс нутаг бүрийн Хуульчдын холбоо, Хуульчдын нийгэмлэг нь тус тусын баталсан дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

Австрали Улс нь эрх зүйн тогтолцооны хувьд нийтлэг эрх зүйн бүлд хамаардаг. Австралид “хуульч” гэж хуулийн мэргэжил эзэмшсэн этгээдийг ойлгох бөгөөд хуульчийг барристер⁶³ болон солиситор⁶⁴ гэж ангилна. Барристер нь хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн, шүүхийн танхимд үйлчлүүлэгчийн эрх ашгийг төлөөлөн оролцдог хуульч буюу өмгөөллийн чиглэлээр дагнасан, ганцаарчлан ажиллах боломжтой хуульчийг хэлдэг. Харин солиситор нь үйлчлүүлэгчтэй тулж харилцдаг, үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгч, хууль зүйн

⁶³ Барристер (*Barrister*) нь өмгөөлөгчийн нэгэн төрөл бөгөөд бүх шүүхэд өмгөөлөл хийх эрхтэй. Барристер бүхий л шүүн таслах ажиллагаанд хууль зүйн хамгийн нарийн төвөгтэй асуудлаар дүгнэлт гарган, үйлчлүүлэгчийнхээ төлөө аман өмгөөлөл хийж, талуудыг төлөөлөх ба хэрэгт хамаарах бүхий л баримт бичигт гарын үсгээ зурж шүүхэд өгөх зэрэг эрх эдэлнэ, С.Нарангэрэл, Хууль зүйн англи-монгол эх толь, УБ., 2012, 83 дахь тал.

⁶⁴ *Solicitor* нь хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн чиг үүрэг гүйцэтгэдэг өмгөөлөгч бөгөөд барристерт материал бэлтгэж өгдөг хуульч, Засгийн газар буюу департамент, хотын захиргаа зэрэгт байдаг хууль зүйн тусгай албан тушаал, С.Нарангэрэл, Хууль зүйн англи-монгол эх толь, УБ., 2012, 501 дэх тал.

баримт бичиг бэлтгэж өгдөг бөгөөд бусадтай хамтран хуулийн фирм, төр, хувийн хэвшлийн байгууллага эсхүл Засгийн газрын хууль зүйн туслалцааны байгууллага зэрэг хаана ч ажиллах боломжтой.⁶⁵

Австрали Улсын Хуульчдын холбоо (Australian Bar Association) нь 1963 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр анхны Их хурлаа хийж үүсгэн байгуулагдсан ба Холбооны гишүүн нь бие даасан гишүүд болон зургаан муж улс, хоёр бүс нутгийн Хуульчдын холбоодоос бүрддэг. Австрали Улсын Хуульчдын холбооны дүрэм⁶⁶-ийн 4 дүгээр зүйлд зааснаар Холбоо нь өөрт олгогдсон бүрэн эрх, хөрөнгө, орлогыг зөвхөн байгууллагын зорилго, гэнэтийн болон бусад зорилгод нийцүүлэн захиран зарцуулах эрхтэй хуулийн этгээд байна. Мөн Холбоо нь ашгийн төлөө бус, гишүүддээ шууд болон шууд бус хэлбэрээр аливаа ашиг, орлого, хөрөнгө хуваарилахыг хориглодог. Харин гишүүдийнхээ зохих ёсоор гаргасан зардлыг нөхөн төлөх, тухайн гишүүн нь гишүүн бус байсан хэдий ч гишүүний адил үнэнч шударгаар тухайн ажлыг гүйцэтгэсэн бол нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг төлж болдог.

Австрали Улсын Хуульчдын холбооны бүрэлдэхүүнд хамаарах муж улс, бүс нутгийн Хуульчдын холбоод нь жил бүр Зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр татвар төлнө.⁶⁷ Татварын хэмжээ, төлөх өдрийг Зөвлөлөөс баталсан журмаар тогтоох бөгөөд тухайн журмыг батлахад дор хаяж зургаан муж улсын холбоо зөвшөөрснөөр хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ. Муж улс, бүс нутгийн холбоо нь татвараа төлснөөр санал өгөх болон бусад дүрэмд заасан эрх эдэлнэ. Харин бие даасан гишүүд нь Холбооны гишүүний хувиар аливаа хандив, татвар төлөхгүй.

Муж улсын Хуульчдын нийгэмлэг. Австрали Улсын Хуульчдын холбоо шиг Хуульчдын нэгдсэн нийгэмлэг Австрали Улсад байхгүй хэдий ч муж улс, бүс нутаг бүр Хуульчдын нийгэмлэгтэй. Иймээс энэхүү

⁶⁵ The Australian Legal System⁶ <http://www.ankarabarusu.org.tr>

⁶⁶ Australian Bar Association Limited Constitution, ABA Constitution⁸ ABN 14 605 949 148, 20176. <https://austbar.asn.au>, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

⁶⁷ Австрали Улсын Хуульчдын холбооны дүрмийн 12-р зүйл. <https://austbar.asn.au>, ABA Constitution

судалгаанд Австрали Улсын хамгийн олон гишүүнтэй Шинэ Өмнөд Уэльс⁶⁸ муж улс Хуульчдын нийгэмлэгийг сонгон авч, судалсан болно. Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэг нь Австрали Улсын 2001 оны Корпорацын тухай хуульд⁶⁹ заасан баталгаат, хязгаарлагдмал нээлттэй компани⁷⁰ бөгөөд үйл ажиллагаа нь дүрмээр⁷¹ зохицуулагддаг. Солиситор гишүүн болон хамтрагч гишүүн нь Зөвлөлөөс өөрөөр тогтоогоогүй бол жил бүр гишүүнчлэлийн хураамж төлнө. Гишүүнчлэлийн төрөл, хамрагдах үйлчилгээ, гишүүнд үзүүлэх хөнгөлөлт зэргээс хамаарч Зөвлөл гишүүнчлэлийн хураамжийг ялгаатай тогтоож болно. Хүндэт болон насан туршийн гишүүд нь гишүүнчлэлийн хураамж төлөхгүй, мөн хуулийн фирмийн, оюутан гишүүд Зөвлөлөөс тогтоосноос бусад тохиолдолд гишүүнчлэлийн хураамж төлөхгүй.

2.1.3. Япон Улсын Хуульчдын холбоо

Япон Улсын Хуульчдын холбоо нь 1949 онд байгуулагдсан бөгөөд хүний үндсэн эрх, нийгмийн шударга ёсны ойлголтыг хамгаалах, хуульчдын гүйцэтгэх үүргийг тодорхойлох⁷², хуульчдын мэргэжлийн үйл ажиллагааг ахисан түвшинд сайжруулж тэдний нэр хүндийг хадгалах зорилгоор нийт өмгөөлөгч, өмгөөлөгчдийн хяналт, харилцаа холбоо,

⁶⁸ 2021 оны 1 дүгээр сарын байдлаар Шинэ Өмнөд Уэльс муж улсад хамгийн олон буюу 2,391 хуульч Хуульчдын холбоонд гишүүнчлэлтэй байна.
[https://austbar.asn.au/Member Information](https://austbar.asn.au/Member%20Information)

⁶⁹ Corporations Act, 2001.
<https://www.legislation.gov.au,> Corporations Act 2001, сүүлд хандсан огноо: 2021.11.05.

⁷⁰ A public company limited by guarantee - Австрали Улсын Корпорацын тухай хуульд зааснаар хязгаарлагдмал компанийг хувьцаат, баталгаат, хувьцаат болон баталгаат, хязгаарлагдмал компани гэж ангилдаг. Баталгаат, хязгаарлагдмал нээлттэй компани гэж хувьцаа буюу хувьцаа эзэмшигчгүй, гишүүдээс бүрдэх, гишүүн бүр нэг саналын эрхтэй бөгөөд ашгийн төлөө бус, үйл ажиллагаа нь дүрмээр зохицуулагддаг, хөрөнгийг байгууллагын зорилгод нийцүүлэн ашигладаг компанийн хэлбэр юм.

⁷¹ Constitution of The Law Society of New South Wales.
[https://www.lawsociety.com.au/NSW Constitution,](https://www.lawsociety.com.au/NSW%20Constitution) сүүлд хандсан огноо: 2021.11.05.

⁷² Япон Улсын Өмгөөлөгчийн хуулийн 8 дугаар зүйл, Attorney Act, Act No. 205 of June 10, 1949.
<https://www.japaneselawtranslation.go.jp,> [Law text] - Attorney Act.

удирдамжтай холбоотой асуудлыг зохицуулдаг.⁷³

Тус Холбоо үйл ажиллагаандаа Холбооны дүрэм⁷⁴, Өмгөөлөгчийн тухай хууль, Гадаад хуульчдын хууль зүйн үйлчилгээг зохицуулахтай холбогдсон тусгай арга хэмжээний тухай хууль⁷⁵, тус хуулийг хэрэгжүүлэх тогтоол⁷⁶, Гадаадын тусгай гишүүдийн үүргийн тухай үндсэн дүрэм⁷⁷, Үйл ажиллагаа явуулж буй өмгөөлөгчдийн үүргийн тухай үндсэн дүрэм⁷⁸, Бүртгэлтэй гадаад хуульчдын үүргийн тухай үндсэн дүрэм⁷⁹, Үйлчлүүлэгчийг тодорхойлж баталгаажуулах болон тэмдэглэл хадгалахтай холбогдсон журмууд⁸⁰, Сахилгын хурлын тэмдэглэлийг задруулахтай холбоотой дүрмүүд,⁸¹ Бүртгэлтэй гадаад хуульчдын оффисын нэрийн талаарх дүрмүүд⁸²-ийг мөрддөг.

2.1.4. Постсоциалист орнуудын Хуульчдын холбоо

ОХУ: ОХУ-д Хуульчдын холбоо, Холбооны өмгөөлөгчдийн танхим хоёр зэрэгцэн үйл ажиллагаа явуулдаг. Тус улсын Хуульчдын холбоо нь 2005 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуульчдын анхдугаар хурлаар байгуулагдсан олон нийтийн нэгдэл юм.⁸³ Холбоо нь үйл ажиллагаандаа

⁷³ Япон Улсын Өмгөөлөгчийн хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp>, [Law text] - Attorney Act.

⁷⁴ Article of Association of Japan Federation of Bar Associations.
<https://www.nichibenren.or.jp>

⁷⁵ Act on Special Measures concerning the Handling of Legal Services by Foreign Lawyers.

⁷⁶ Ordinance for Enforcement of the Act on Special Measures concerning the Handling of Legal Services by Foreign Lawyers.
<https://www.nichibenren.or.jp>

⁷⁷ Basic Rules on the Duties of Foreign Special Members.

⁷⁸ Basic Rules on the Duties of Practicing Attorneys.
<https://www.nichibenren.or.jp>

⁷⁹ Basic Rules on the Duties of Registered Foreign Lawyers.
<https://www.nichibenren.or.jp>

⁸⁰ Regulations Concerning Client Identity Verification and Record Preservation (Adopted on December 20, 2012: Regulations No.
<https://www.nichibenren.or.jp>

⁸¹ Rules Concerning Disclosure of Disciplinary Records.
<https://www.nichibenren.or.jp>

⁸² Rules on Office Name of Registered Foreign Lawyers.
<https://www.nichibenren.or.jp>

⁸³ Оросын Хуульчдын Холбооны анхдугаар хурлын протокол №1.
https://alrf.ru/upload/medialibrary/0ff/Protocol_Uchreditelno_seezda_AYR.pdf.

ОХУ-ын Үндсэн хуулийг удирдлага болгон ОХУ-ын Олон нийтийн нэгдлийн тухай хууль⁸⁴, Оросын Хуульчдын холбооны дүрэм⁸⁵, Оросын хуульчдын холбооны бүсийн болон орон нутгийн салбарын дүрэм⁸⁶, Холбооны улсын тойрог дахь Оросын Хуульчдын холбооны Бүсийн зөвлөлийн дүрэм⁸⁷, Оросын Хуульчдын холбоонд гишүүн элсүүлэх болон нэгдсэн бүртгэл хөтлөх дүрэм⁸⁸, Оросын хуульчдын холбооны удирдлагын дүрэм⁸⁹ болон Холбооноос баталсан бусад дүрэм, журмыг баримтална. Холбооны дүрмийн нэгд зааснаар Оросын хуульчдын холбоо нь тодорхой зорилго хэрэгжүүлэхээр нэгдсэн сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийгөө удирдах тогтолцоо бүхий бие даасан байгууллага байна. Холбооны дүрмийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Холбооны гишүүн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Холбооны үйл ажиллагаанд оролцох;
- Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон тохиолдолд Холбооны Их хуралд оролцох;
- Олон нийтийн хуралд оролцох эсхүл харьяалах салбар холбооны хуралд оролцох.

Холбооны дүрмээс гадна ОХУ-ын Хуульчдын холбооны Зөвлөлийн даргын 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “ОХУ-ын Хуульчдын холбооны бүсийн болон орон нутгийн салбарын дүрэм”-д зааснаар төлөөлөгчийн газар, салбартай байж болно. Холбооны бүсийн

⁸⁴ Федеральный закон от 19.05.1995, N 82-ФЗ, “Об общественных объединениях”. <http://www.consultant.ru>

⁸⁵ Устав общероссийской общественной организации Ассоциация юристов России. <https://alrf.ru>

⁸⁶ Положение о региональных и местных отделениях Общероссийской общественной организации “Ассоциация юристов России”. <https://alrf.ru>

⁸⁷ Положение об окружном Совете Общероссийской общественной организации “Ассоциация юристов в России” в федеральных округах. <https://alrf.ru>

⁸⁸ Положение о порядке приема в члены Общероссийской общественной организации “Ассоциация юристов России” и ведении Единого реестра Общероссийской общественной организации “Ассоциация юристов в России”. <https://alrf.ru>

⁸⁹ Положение о Правлении Ассоциации юристов в России. <https://alrf.ru>

салбар нь ОХУ-ын засаг захиргааны нэгж (холбооны улс, хязгаар, холбооны зэрэглэлтэй хот, өөртөө засан тогтнох эрхтэй хязгаар, тойрог)-д үндэслэн байгуулагдана. Холбооны Зөвлөлийн шийдвэрээр нэг засаг захиргааны нэгжид Холбооны нэг салбар байх бөгөөд салбар нь хуулийн этгээдийн эрхтэй байдаг.

Холбооны өмгөөлөгчдийн танхим нь ОХУ-ын Үндсэн хууль, ОХУ-ын өмгөөлөгчийн үйл ажиллагаа болон Өмгөөллийн тухай хууль, ОХУ-ын Арилжааны бус байгууллагын тухай хууль, танхимын дүрэмд үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг.⁹⁰ Холбооны өмгөөлөгчдийн танхим нь өөрийн нэрийн өмнөөс өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд аливаа хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хатуу хориглодог. Мөн төрийн болон орон нутгийн байгууллагын тогтолцоонд хамаарахгүй.

Литва Улс: Литва Улсын Хуульчдын холбоо анх 1920 онд “Тангарагтан өмгөөлөгчдийн зөвлөл” нэртэйгээр байгуулагдсан байсан. Тус Холбоог Сейм (Парламент)-ээс 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдөр баталсан ба Хуульчдын холбооны тухай хууль (*Law on the Bar*) болон Холбооноос баталсан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Мөн Литва Улсын хувьд Хуульчдын холбооны тухай хуульд зааснаар⁹¹ тус улсад байнга оршин суудаг Европын холбооны гишүүн улсын хуульчийн эрх зүйн байдлыг хуулиараа зохицуулдаг онцлогтой. Тус Холбооны чиг үүргийг зөвхөн өмгөөлөгчийн үйл ажиллагаагаар тодорхойлж, хуульчийн мэргэжлийн удирдах ёсны байгууллагын бусад чиг үүргийг хэрэгжүүлдэггүй байна. Өмгөөлөгчийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг үргэлжилсэн сургалтыг зөвхөн Хуульчдын холбоо зохион байгуулдаггүй, бусад хуулийн фирмээс зохион байгуулдаг онцлогтой.

Беларусь Улс: Тус улсад хууль дээдлэх, эх оронч байх болон ёс суртахууны үнэт зүйлсийг хүндэтгэх зарчимд үндэслэн хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, иргэний нийгмийг хөгжүүлэх зорилгоор “Бүгд Найрамдах Беларусь Улсын Хуульчдын нэгдсэн зөвлөл”-ийг 1990 оны

⁹⁰ Федеральная палата адвокатов РФ.
<https://fparf.ru>

⁹¹ *Ibid.*

6 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан. Хуульчдын нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагааг 1994 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Олон нийтийн нэгдлийн тухай хууль, Зөвлөлөөс баталсан эрх зүйн хэм хэмжээний актуудаар зохицуулдаг.

ОХУ-ын нэгэн адил Беларусь Улсад Хуульчдын нэгдсэн зөвлөл, Өмгөөлөгчдийн холбоо хоёр зэрэгцэн оршиж, тусдаа бие даасан үйл ажиллагаа явуулдаг. Хуульчдын нэгдсэн зөвлөлөөс гадна бүсийн болон Минск хотын салбаруудаар дамжуулан хуульчийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлогтой.

Монгол Улсад МХХ, МӨХ зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотойгоор аль нэг байгууллага дангаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж зарим хуульч байр сууриа илэрхийлдэг. Харьцуулсан судалгаанд авч үзсэн улс орнуудын тухайд Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо хоёр зэрэгцэн үйл ажиллагаа явуулах, холбоо нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байхыг хориглосон зохицуулалт байхгүй байна. Учир нь хуульчдын мэргэжлийн нэр хүндийг хамгаалах зорилгын дор хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг давхардуулахгүйгээр хэрэгжүүлж, холбоодын үйл ажиллагаа болон гишүүнчлэлийн ялгаатай байдлыг үүсгэжээ. Иймээс МХХ, МӨХ-ны чиг үүргийг тодорхой болгох, гишүүдийг төрөлжүүлэх хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа тул дараагийн бүлэгт Хуульчдын холбооны чиг үүргийг мөн харьцуулан судалсан болно.

2.2. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

2.2.1. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж буй байдал

АНУ-ын Хуульчдын холбоо, Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэг, ОХУ-ын Хуульчдын холбоо, Беларусь Улсын Хуульчдын зөвлөлийн зорилго, хэрэгжүүлж буй бүрэн чиг үүргийг харьцуулан судалж нэгтгэн дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Гадаад улсуудын Хуульчдын холбоодын чиг үүрэг

Зорилго	Чиг үүрэг
<p>АНУ-ын Хуульчдын холбоо нь бүх гишүүдэд ижил тэгш үйлчлэх, хууль зүйн үндэсний мэргэжилтнээр дамжуулан нийгэмд шударга ёс, эрх чөлөөг хангах зорилготой.</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Хууль дээдлэх ёсыг хөгжүүлэх хүрээнд:</i> Улс болон дэлхий даяар хууль зүйн мэргэжлийн үүрэг, хууль зүйн процесс, хууль дээдлэх ёсыг хүндэтгэн ойлгох, нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, Засгийн газрыг хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг болгох, шударга хууль зүйн процесс, хүний эрхийн болон хуулиудын төлөө ажиллах, шүүх эрх мэдэл болон хууль зүйн мэргэжлийн хараат бус байдлыг хадгалах; - <i>Гишүүдэд үйлчлэх хүрээнд:</i> Гишүүдийн мэргэжлийн болон амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн ашиг тустай хөтөлбөр, үйлчилгээгээр хангах; - <i>Мэргэжил дээшлүүлэх хүрээнд:</i> Хамгийн өндөр түвшинд хууль зүйн боловсролыг дэмжих, мэргэжил, ёс зүйн үйлдэл болон өрсөлдөх чадварыг дэмжих, нийтэд зориулсан хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ, пробоно үйлчилгээг дэмжих; <p><i>Тэгш бус байдлыг арилгах ба ялгарлыг дэмжих хүрээнд:</i> Мэргэжлийн болон холбооны үйл ажиллагаанд гишүүдийн тэгш оролцоо, шударга ёсны тогтолцоог хүн бүрд тэгш, бүрэн хангах.</p>
<p>Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэг нь хууль тогтоомжийг сайжруулах, шинэчлэлтийг дэмжих, хуульчийн мэргэжлийн нийгэмд эзлэх байр суурийг тогтвортой хариуцлагатай байлгах, хуулийн судалгааг дэмжих, гишүүдийн ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилготой.</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Нийгэмлэгийн үйл ажиллагааг удирдах хүрээнд:</i> Нийгэмлэгийн нэрээр үйл ажиллагаа явуулах, эрх үүргийг хэрэгжүүлэх, үйлчилгээ авах, гэрээ байгуулах, Зөвлөлийн гишүүдийн томилолтын зардал болон бусад зардлыг төлөх, Нийгэмлэгийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах, Нийгэмлэгийн үйл ажиллагааны зардлыг төлөх; - <i>Эрх мэдлээ шилжүүлэх хүрээнд:</i> Зөвлөл нь хууль, дүрмээр олгогдсон эрх, үүргээ солиситор гишүүдээс бүрдэх хороодод шилжүүлэх, Гүйцэтгэх захирал, нийгэмлэгийн бусад ажилтанд шилжүүлэх; - <i>Хуульчдын нийгэмлэгийг төлөөлөх хүрээнд:</i> Ерөнхийлөгч эсхүл Зөвлөл нь нийгэмлэгийг аливаа Засгийн газар, Засгийн газрын байгууллагын өмнө төлөөлөх.

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

<p>ОХУ-ын Хуульчдын холбоо нь нийт гишүүний тэгш эрхийг хангах, хууль дээдлэх, ил тод байх, сайн дурын үндсэн дээр өөрийн удирдлагыг бие даан хэрэгжүүлэх зорилготой.</p>	<ul style="list-style-type: none"> - ОХУ дахь хууль дээдлэх, эрх зүйт ёсыг хөгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; - Хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, журмуудыг сахиулж, ОХУ дахь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэр хүндийг дээшлүүлэх; - Холбооны гишүүдэд мэргэжлийн болон нийтэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; - Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл болон нийгэм-эрх зүйн хамгаалалтыг хууль тогтоомжид тусгах; - Эвлэрүүлэн зуучлах байгууллага байгуулах эсхүл тус байгууллагыг байгуулахад оролцох замаар эдийн засгийн болон бусад маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх; - Хүмүүнлэг, энх тайвны байдлын талаарх олон нийтийн санаачилга бүхий олон улсын болон үндэсний төсөл, хөтөлбөрийг төрийн ба төрийн бус байгууллагаас хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбооноос оролцох боломж бүрдүүлэх; - Хуульчид хоорондын хамтын ажиллагааг дэмжих; - Хууль зүйн дээд боловсрол, хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажиллах хүчний чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хууль зүйн салбарын орчин үеийн хандлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Хууль бүтээх ажиллагааны шинжлэх ухаанч үндэслэлтэй байдал, ардчилсан болон ил тод байдлыг өргөжүүлэх, мөн хууль хэрэгжүүлэх практикийг судалж, боловсронгуй болгох үйл ажиллагаанд тус тус дэмжлэг үзүүлэх; - Олон улсын, үндэсний, бүсийн хууль зүйн байгууллагын хамтын үйл ажиллагааг нэгтгэж, байгууллага хоорондын хүлээн зөвшөөрөгдөх байдал, найрамдалт харилцаа, итгэлцлийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх.
---	---

Беларусь Улсын Хуульчдын зөвлөл нь эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нийгмийг хөгжүүлэх, эрх зүйт төрийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, хуульчдын дунд эв нэгдэл, хуульчийн мэргэжлийн соёлыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Беларусь Улсад хуульчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.	<ul style="list-style-type: none"> - Хуульчдын зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах; - Үндэсний хууль тогтоомжийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг судлах, хууль хэрэгжүүлэх практикийг бүрдүүлж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмж бэлтгэх; - Эрх зүйн тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох асуудлаар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх; - Хууль санаачлагчийн хуулийн төсөлд санал оруулах замаар хууль бүтээх ажиллагаанд оролцох; - Нэн чухал хууль тогтоомжийн төслөөр нийтийн дунд хэлэлцүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулах, гишүүдийн оролцоог хангах; - Эрх зүйн боловсрол, эвлэрүүлэн зуучлал зэрэг салбарыг хөгжүүлэх асуудлаар дэмжлэг үзүүлж ажиллах; - Хуульчийн сул орон тоо, ажлын байрны зарлал болон эрх зүйн бусад салбараар мэдээллийн сантай болох; - Хууль зүйн мэргэжлийн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажилд оролцох; - Хууль зүйн туслалцаа үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааны олон нийтийн үнэлгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх; - Олон улсын бусад байгууллагатай харилцаа тогтоох.
---	--

Манай улсын хувьд хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллага нь хууль дээдлэх ёсыг хөгжүүлэх, хуульчийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалах, хуулийн судалгааг бодлогын түвшинд дэмжих, хуульчийн мэргэжлийн хариуцлагатай байдлыг сайжруулах зорилгоор (i) нийтийн ашиг сонирхол, хүний эрхийг дээдлэх; (ii) холбооны гишүүдэд үйлчлэх; (iii) хуульчийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх; (iv) хуульчдын чадварыг сайжруулах хүрээнд нарийвчилсан чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж байна. ХЭЗБТХ-ийн төслийн⁹² 31.1 дэх хэсэгт зохицуулсан Хуульчдын холбооны гүйцэтгэх чиг үүрэгт хуульчийн мэргэжлийн

⁹² Засгийн газраас ХЭЗБТХ-ийн төслийг 2021.05.12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

чадварыг хөгжүүлэх зорилгоор хууль эрх зүйн судалгааны ажил гүйцэтгэх, мэргэжлийн хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх, гишүүдийн ашиг сонирхолд нийцүүлэн үйлчилгээ санал болгох зэрэг чиг үүргийг хуульд тусгах нь зүйтэй.

2.2.2. Өмгөөлөгчийн гишүүнчлэлтэй холбоодын чиг үүрэг, тэдгээрийн онцлог

Австрали, Япон, Литва улсуудын Хуульчдын холбоод нь гишүүнчлэлийн хамрах хүрээг хязгаарлагдмал байдлаар тодорхойлон, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын зарим чиг үүрэг болох өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үүсэх асуудлыг зохицуулж байна.

Австрали Улсын Хуульчдын холбоо нь дүрэмд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хууль дээдлэх ёсыг хангах;
- Үр дүнтэй шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Австралийн бүх муж улс, бүс нутагт Холбооны бие даасан байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх;
- Гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах;
- Гишүүдэд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, сайжруулах;
- Гишүүд үзэл бодлоо илэрхийлэх болон барристеруудад хамаарах мэдээлэл, мөрддөг нийтлэг стандарт, дүрэм, журам батлах зорилгоор Австрали Улсын Хуульчдын холбоодын гишүүдийн нэгдэл байгуулах;
- Австрали Улсын холбооны болон бусад шүүх, төрөлжсөн шүүхтэй холбоотой барристеруудад тулгамдсан асуудлын хүрээнд Австрали Улсын Хуульчдын холбооны нэгдсэн бодлого боловсруулах;
- Барристеруудын болон барристер болохоор бэлтгэж байгаа хүмүүст зориулсан сургалтын материалыг сайжруулах;

- Өмгөөллийн сургалтаар дамжуулан шүүн таслах ажиллагааны бусад оролцогчдод туслах;
- Австрали Улсын Хуулийн зөвлөл болон Зөвлөлийн тодорхойлсон бусад байгууллагатай хамтран ажиллах;
- Мэргэжлийн чадварыг дэмжих зорилгоор хэвлэн нийтлэлийн ажил зохион байгуулах;
- Холбооны шүүхэд болон Засгийн газрын бусад байгууллагуудын өмнө барристеруудыг төлөөлөх.

Япон Улсын Хуульчдын холбоо нь нийт өмгөөлөгчийг төлөөлсөн аль нэг байгууллагаас хараат бус өөрийн удирдлагыг өндөр түвшинд хадгалах зорилготой бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- *Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, эрх зүйт ёсыг дээдлэх хүрээнд:*
 - Япон Улсын дотоодод болон гадна бий болж буй хүний эрхийн асуудлуудыг тодорхойлох, хүний эрхийн зөрчлөөс хамгаалах, олон улсын хүний эрхийн стандарт, механизмуудыг хөгжүүлэх, сайжруулах ажлыг дэмжих;
 - Гадаад улсад Хуульчдын холбоо байгуулах, өмгөөлөгчдийг сургах, хууль зүйн системийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг өргөжүүлэх;
 - Өмгөөлөгчдийн нийгэмд үзүүлж буй дэмжлэг, тэдгээрийн мэргэжлийн ёс зүйг бий болгохтой холбоотой үйл ажиллагааг өргөжүүлэх;
 - Олон улсын хүний эрхийн чиглэлээр эрх зүйн тусалцаа үзүүлдэг өмгөөлөгчдийн туршлага, ур чадварыг сайжруулах сургалт, хөтөлбөр явуулах, өмнөх хэсэгт дурдсан үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх;
- *Хуульчдын холбоо болон хууль зүйн мэргэжлийн үүргийн хүрээнд:*
 - Өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, олон улсын Хуульчдын холбооны жишиг практик, зохицуулалтыг

нэвтрүүлэх, олон улсын түвшний мэдлэг, туршлага хуримтлуулж, гишүүдэд түгээх;

- Олон улсын байгууллага, Хуульчдын холбоодтой хамтран ажиллаж, олон улсын мэдээллийн эргэлт бий болгох, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын түвшинд нийцүүлэн сайжруулах хүрээнд стандарт тогтоох ажлыг эрчимжүүлэх;
- Олон улсын түвшинд шийдвэр гаргах ажиллагаанд газар зүйн тэнцвэртэй байдлыг хангах хүрээнд арьс өнгө, жендер, хууль зүйн соёлын ялгаатай байдлыг харгалзах, тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх;
- *Нийгмийн олон төрлийн хууль зүйн хэрэгцээнд нийцсэн хууль зүйн үйлчилгээгээр хангах бүтцийг сайжруулах хүрээнд:*
 - Хувь хүн, хуулийн этгээд олон улсад болон дотоодод хууль зүйн ба шүүхийн үйлчилгээ авах тогтолцоог сайжруулах;
 - Өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааны цар хүрээ, мэдлэг, туршлагыг олон улсын хэмжээнд нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах, шаардлагатай үйл ажиллагааг өргөжүүлэх.

Литва Улсын Хуульчдын холбоо нь хуульд⁹³ зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өмгөөллийн үйл ажиллагааг зохицуулах;
- Төрийн байгууллага болон олон улсын, гадаадын байгууллагын өмнө өмгөөлөгчийн ашиг сонирхлыг төлөөлөх;
- Өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар эрх зүйн хэм хэмжээний акт боловсруулан, Бүгд Найрамдах Литва Улсын Хууль зүйн яамд хүргүүлэх;
- Өмгөөллийн үйл ажиллагаа дахь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

⁹³ Литва Улсын Хуульчдын холбооны тухай хуулийн 57-р зүйл. Republic of Lithuania Law on the Bar. <https://e-seimas.lrs.lt, IX-2066 Law on the Bar>.

- Өмгөөлөгчийн мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх ажил зохион байгуулах;
- Хуулиар тогтоосон бусад үйл ажиллагааг эрхэлнэ.


Дээр дурдсанчлан, өмгөөлөгчийн гишүүнчлэлтэй хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага нь гишүүнчлэлийн хувьд хязгаарлагдмал, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхгүй байх боловч өмгөөллийн үйл ажиллагааны хүрээнд хууль дээдлэх ёсыг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хууль тогтоомжийг хөгжүүлэх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

2.3. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын бүтцэд ерөнхийдөө эрх барих дээд байгууллага (Хурал), Зөвлөл (*Council*), Ерөнхийлөгч (*Presidents*), Гүйцэтгэх байгууллага, Хяналтын зөвлөл болон Хороод (*Committees*), орон нутаг, бүс нутгийн бусад холбоод (*Local association*) багтдаг. Харьцуулсан судалгаагаар гадаад улсуудын хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн бүрэн эрхийг дараах байдлаар нарийвчлан судаллаа.

2.3.1. АНУ-ын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт

Зураг 4. АНУ-ын Хуульчдын холбооны бүтэц⁹⁴



⁹⁴ АНУ-ын Хуульчдын холбооны веб хуудас.
https://www.americanbar.org/about_the_aba/

Төлөөлөгчдийн танхим нь Холбооны дээд эрх мэдлийг хэрэгжүүлэгч бөгөөд Холбооны дүрэм, журам, бодлогыг дүрэмд нийцүүлэн батлах, Холбооны Удирдах зөвлөлийн болон Удирдлагын хорооны гишүүдийг сонгодог. Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчид нь хуульчийн мэргэжлийн төлөөлөл байх бөгөөд Холбооны гишүүдээс бүрдэнэ. Тухайлбал,⁹⁵ муж улс болон орон нутгийн Хуульчдын холбоо, Шүүхийн хороо, Залуу хуульчдын хороо зэрэг бусад хороо, Холбооны одоогийн болон өмнөх Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, Ерөнхий атторнэй, дэд эсхүл орлогч Ерөнхий атторнэй, Зөвлөх атторнэй, Шүүхийн захиргааны газрын дарга, Конгресс, Гадаад болон олон нийтийн харилцаа хариуцсан орлогч дарга, салбар байгууллагуудын төлөөлөл байгууллага, цөөнхийн төлөөлөл, тусгайлсан нутаг дэвсгэрийн төлөөлөл багтдаг.

Удирдах зөвлөл нь Холбооны удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд Холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй, дэмжлэг үзүүлж чадахуйц арга хэмжээ авч ажиллана. Холбооны Төлөөлөгчдийн танхимын хурал хоорондын хугацаанд Удирдах зөвлөл үйл ажиллагаа явуулах бөгөөд Төлөөлөгчдийн танхимын чиг үүрэг, үйл ажиллагаанд уялдуулан ажиллана.

АНУ-ын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн хурлыг Төлөөлөгчдийн танхимын хурал бүрийн өмнө заавал хийх бөгөөд жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Хурал хоорондын зай дөрвөн сараас хэтрэх ёсгүй. Зөвлөлийн ээлжит бус хурлыг Ерөнхийлөгч эсхүл Зөвлөлийн санал өгөх эрхтэй гурав буюу түүнээс дээш гишүүний хүсэлтээр хуралдуулна. Зөвлөлийн санал өгөх эрхтэй гишүүдийн олонх ирснээр хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.

Сонгогддог албан тушаалтнууд: Холбооны Ерөнхийлөгч, сонгогдоод батламжлагдаагүй Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхимын дарга, Нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан менежер нь сонгогддог албан тушаалтнууд байна. Удирдах зөвлөлөөс захиргааны бүтэн цагийн ажилтнуудын албан тушаалыг тогтоон, тэдгээрийг томилох бөгөөд

⁹⁵ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 6.2 дахь хэсэг.
<https://www.americanbar.org/2020-2021-constitution-and-bylaws.pdf>

тэд Зөвлөлөөс тодорхойлсон ажил, үүрэг гүйцэтгэнэ. Захиргааны ажилтнуудаас бусад албан тушаалтан бүгд Холбооны гишүүн байдаг.

Сонгууль ба хугацаа: а) Ерөнхийлөгчийг Төлөөлөгчдийн танхимын тухайн жилийн ээлжит хуралдаанаар сонгох ба бүрэн эрхийн хугацаа нэг жил буюу дараагийн ээлжит хурал хүртэл үргэлжилнэ. б) Төлөөлөгчдийн танхимын даргыг танхимын тэгш тоотой жилийн ээлжит хурлаар сонгоно. Даргын бүрэн эрхийн хугацаа сонгогдсон хугацаанаас эхлэн хоёр жил байна. Дарга нь бүрэн эрхийн хугацаанд Холбоонд бусад албан тушаал хайхгүй бөгөөд хашихгүй. Даргыг чөлөөлснөөс хойш хоёр жилийн хугацаанд тухайн албан тушаалд болон сонгогдсон Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвших боломжгүй. в) 2020 оноос эхлэн Холбооны Нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан менежерийг Холбооны Төлөөлөгчдийн танхимын жилийн ээлжит хуралдаанаас шууд гурван жилийн хугацаагаар сонгох болсон. Нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан менежер нь тухайн албан тушаалд дахин ажиллах боломжгүй.

Сул орон тоо: Ерөнхийлөгчийн орон тоо сулрах тохиолдолд үлдсэн бүрэн эрхийн хугацаагаар сонгогдоод батламжлагдаагүй байгаа ерөнхийлөгч Ерөнхийлөгч (дээр буй “Сонгогддог албан тушаалтнууд” хэсгийг харна уу) болно. Сонгогдсон Ерөнхийлөгчийн орон тоо сулрах тохиолдолд Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшигчийг тодорхойлох ба Төлөөлөгчдийн танхимын дараагийн хурлаар сонгоно. Дээрх албан тушаалын орон тоо нэгэн зэрэг сулрах, сонгогддог албан тушаалтнуудын аль нэг орон тоо сулрах тохиолдолд Удирдах зөвлөлөөс сул орон тоонд үлдсэн бүрэн эрхийн хугацаанд шаардлага хангасан гишүүнийг сонгож ажиллуулна. Холбооны Нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан менежер нас барах, албан тушаалаас татгалзах, шаардлага хангахгүй болсон шалтгаанаар орон тоо сулрах тохиолдолд Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшигчийг Удирдах зөвлөлд мэдэгдэж, Төлөөлөгчдийн танхимын дараагийн хуралдаанаар сонгоно. Үлдсэн бүрэн эрхийн хугацаанд ажилласан албан тушаалтны тухайн албан тушаалд дахин нэр дэвших боломжийг хязгаарлахгүй.

Холбоо нь хэсэг болон салбаруудтай байх ба АНУ-ын Хуульчдын холбоо нь 21 хэсэг, 7 салбартай.

Хороод: Үндсэн болон тусгай хороод үйл ажиллагаа явуулдаг. Үндсэн хороод нь Холбооны үйл ажиллагааны зорилготой холбогдсон асуудлаар тогтмол хяналт шалгалт хийх, үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй. Хороодын үйл ажиллагааны зорилго, зохицуулах асуудал, газраас хамааран хороод байгуулан үйл ажиллагаа явуулдаг. *Мэргэжлийн болон Ёс зүйн хариуцлагын хорооны* чиг үүргийг Төлөөлөгчдийн танхимаас тогтоож, Хорооны гишүүнийг Ерөнхийлөгч томилох бөгөөд тус хороо 10 гишүүнтэй байна. Тус хороо дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хуульчдын холбооны гишүүн эсхүл шүүгчдээс гаргасан хүсэлтээр эсхүл хороо өөрийн санаачилгаар хууль зүйн үйл ажиллагаа болон шүүхийн үйл ажиллагаанд баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээний талаарх дүгнэлтийг гишүүдийн олонхын санал, оролцоотойгоор гаргах;
- Хорооноос гаргасан дүгнэлтийг олон нийтэд хэсэгчлэн болон товч дүгнэлт хэлбэрээр тогтмол хүргэх, Хуульчдын холбооны гишүүн эсхүл шүүгч, олон нийтийн хүсэлтээр хуулбарыг гаргаж өгөх;
- Хүчин төгөлдөр мөрдөж буй болон Хорооны өөрийн гаргасан дүгнэлтийг хэрхэн хэрэглэх талаарх хүсэлтэд өөрийн бүрэн эрхийн хүрээнд албан бус тайлбар өгөх;
- Шүүгчийн ёс зүйн загвар кодекс, өмнө мөрдөгдөж байсан Мэргэжлийн хариуцлагын кодекс, Мэргэжлийн үйл ажиллагааны загвар дүрэм зэрэг мэргэжлийн ёс зүйн стандартуудын агуулгыг тайлбарлах, тэдгээрт оруулсан өөрчлөлт, сайжруулалтын талаар шүүхийн болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хүсэлтээр зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
- Шүүхийн эсхүл Мэргэжлийн үйл ажиллагааны загвар дүрмийг тодруулах, нэмэлт оруулах зөвлөмж гаргах;
- Дүгнэлт гаргах процесстэй холбоотой дүрэм боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлэх.

Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол Холбооны Удирдах зөвлөлийн хороодын гишүүн болон даргыг томилно.⁹⁶

Төлөөлөгчдийн танхимын дарга нь Танхимын болон Нэр дэвшүүлэх хорооны хуралдааныг даргалах, Ерөнхийлөгчийн эзгүйд Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах, Танхимын хороодыг Танхимын дүрэмд заасны дагуу байгуулах, Удирдах зөвлөлийн гишүүдийн сул орон тоог нөхөх болон Танхимаас гаргасан шийдвэрийн тайлан, мэдээллийг муж улс, орон нутаг, салбар хуульчдын хороо руу тухай бүр даруй хүргүүлэх чиг үүрэг гүйцэтгэнэ.⁹⁷ Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн санал хураалтыг заавал бичгээр буюу саналын хуудсаар авахаар заагаагүй тохиолдолд аудио эсхүл цахимаар авна. 100 төлөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд санал хураалтыг санал авах хуудсаар авна.⁹⁸

Муж улсын болон орон нутгийн Хуульчдын холбоо нь сайн дурын үндсэн дээр Холбооны Төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагаанд оролцоно.

Нью Йорк муж улсын Хуульчдын холбоо


Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны удирдлага нь Төлөөлөгчдийн танхим, Холбооны албан тушаалтнууд болон хороодоос бүрдэнэ.

⁹⁶ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 29 дүгээр зүйлд Албан тушаалтнуудын үүргийг заасан ба 29.2 дахь хэсэгт Ерөнхийлөгчийн үүргийг тодорхойлсон.
<https://www.americanbar.org/2020-2021-constitution-and-bylaws.pdf>

⁹⁷ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 29 дүгээр зүйлд Албан тушаалтнуудын үүргийг заасан ба 29.4 дэх хэсэгт Төлөөлөгчдийн Танхимын даргын үүргийг тодорхойлсон.
<https://www.americanbar.org/2020-2021-constitution-and-bylaws.pdf>

⁹⁸ АНУ-ын Хуульчдын холбооны дүрмийн 46.1, 46.2 дахь хэсэг.
<https://www.americanbar.org/2020-2021-constitution-and-bylaws.pdf>

Зураг 5. Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны бүтэц



Төлөөлөгчдийн танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хуульчдын холбооны хөрөнгийн захиран зарцуулалттай холбоотой бодлогыг тодорхойлж, Холбооны үйл ажиллагаа болон гадаад харилцааг удирдах, хяналт тавих;
- Хуульчдын холбооны ажилтнууд болон Удирдлагын хороогоор дамжуулж Холбооны салбар, хороод, Удирдлагын хороо болон албан тушаалтнуудыг хянах, чиглүүлэх, удирдах;
- Хуульчдын холбооны үйл ажиллагааны удирдлага, хяналтад хамаарах гэнэтийн болон шаардлагатай тохиолдолд баримтлах бодлого, зөвлөмжийг тодорхойлж, хэрэгжүүлэх.

Төлөөлөгчдийн танхимын аливаа шийдвэрийг төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш хувийн санал авснаар гаргах бөгөөд шийдвэрийг Хуульчдын холбоо, түүний салбар хороод, ажилтнууд заавал мөрдөнө. Танхим жил бүр дөрвөөс доошгүй удаа хуралдах бөгөөд 100 гишүүн ирснээр хурлын ирц бүрдсэн гэж үзнэ. Нэг төлөөлөгч нэг саналын эрхтэй оролцоно.

Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчид нь бүгд Хуульчдын холбооны гишүүн байх ба дараах төлөөллөөс бүрдэнэ. Үүнд:

1. Хуульчдын холбооны албан тушаалтнууд;
2. Удирдлагын хорооны орон тооны гишүүд;
3. Шүүхийн дүүрэг бүрээс сонгогдсон гурван гишүүн;
4. Хуульчдын холбооны өмнөх Ерөнхийлөгч
5. АНУ-ын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн;
6. Хуульчдын холбооны салбар бүрийн төлөөлөгчид.

Нью Йорк муж улсын Хуульчдын холбооны өмнөх Ерөнхийлөгч, АНУ-ын Хуульчдын холбооны өмнөх болон одоогийн Ерөнхийлөгчид нь Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчөөр хугацаагүй томилогдоно. Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгч байна. Дүрэмд тусгайлан зааснаас бусад тохиолдолд төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхэлнэ.

Ерөнхийлөгч нь Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх ба Удирдлагын хорооны бүх хуралдааныг даргалж, сонгогдсон Ерөнхийлөгчийн эзгүйд Төлөөлөгчдийн танхимын хуралдааныг даргална. Ерөнхийлөгч Хуульчдын холбооны дүрэмд нийцүүлэн АНУ-ын Хуульчдын холбоо, бусад муж улсын болон нутаг дэвсгэрийн Хуульчдын холбоодтой уялдаа холбоотой хамтарч ажиллах үндсэн зорилготой бөгөөд тус зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд шаардлагатай хороог томилж ажиллуулах эрхтэй. Ерөнхийлөгч нь Хуульчдын холбооны бүх хороонд санал өгөхөөс бусад бүх хяналтыг хэрэгжүүлж оролцоно.

Сонгогдсон Ерөнхийлөгч нь сүүлийн таван жилийн хугацаанд Төлөөлөгчдийн танхимд ажилласан байх шаардлагатай. Ерөнхийлөгчийн орон нутгийн Хуульчдын холбоодтой хийх уулзалтад дэмжлэг, тусалцаа үзүүлэх, Төлөөлөгчдийн танхим болон Ерөнхийлөгчөөс даалгасан ажил үүргийг гүйцэтгэнэ. Тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хуульчдын холбооны бүх хороонд санал өгөхөөс бусад бүх хяналтыг хэрэгжүүлж оролцоно. Сонгогдсоны дараах жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс шууд Ерөнхийлөгч болно.

Дэд ерөнхийлөгч нь анхан шатны шүүхийн дүүрэг бүрээс хоёр, бусад шүүхийн дүүргээс тус тус нэг Дэд ерөнхийлөгчийг томилно. Тэдгээр нь Хуульчдын холбоо болон өөрийн томилогдсон шүүхийн дүүрэг, орон нутгийн Хуульчдын холбоодын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллана. Хуульчдын холбооноос хэрэгжүүлж буй үйл ажиллагааг өөрийн харьяалах Хуульчдын холбоо, шүүхийн дүүрэгт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгчийн хийх уулзалт, айлчлалыг зохион байгуулна.

Хороод нь Төлөөлөгчдийн танхимын олонхын саналаар хоёр буюу түүнээс дээш тооны төлөөлөгчөөс бүрдэх тухайлсан хороог байгуулж болох ба хороо байгуулах шийдвэрт хорооны чиг үүрэг болон бүрэн эрхийг тодорхой тусгана. Хороод дараах эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй. Үүнд:

- Холбооны аль нэг гишүүнээс тухайлсан зөвшөөрөл гаргахыг шаардах;
- Төлөөлөгчдийн танхимын болон түүний байгуулсан хорооны сул орон тоог нөхөх;
- Төлөөлөгчдийн танхимын болон түүний байгуулсан хорооны төлөөлөгчдийн цалин хөлсийг тодорхойлох;
- Холбооны дүрмийг өөрчлөх, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилж батлах;
- Төлөөлөгчдийн танхимын аливаа шийдвэрт өөрчлөлт оруулах;
- Хууль, Холбооны дүрэм, Төлөөлөгчдийн танхимын шийдвэрт тусгаагүй эрхийг хэрэгжүүлэх.


Удирдлагын хороо нь Төлөөлөгчдийн танхимд харьяалагдах хороо бөгөөд дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Ерөнхийлөгч;
2. Сонгогдсон Ерөнхийлөгч;
3. Бүх Дэд ерөнхийлөгч;

4. Нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан менежер;
5. Өмнөх Ерөнхийлөгч;
6. Идэвхтэй гишүүдээс найм;
7. Анхан шатны шүүхийн дүүргээс хоёроос доошгүй;
8. Шүүхийн нэг дүүргээс цөөнхийн төлөөлөл хоёроос доошгүй;
9. Төлөөлөгчдийн танхимын салбарын төлөөлөгчөөр сүүлийн гурван жилийн хугацаанд ажилласан хоёр төлөөлөгч;
10. Төлөөлөгчдийн танхимын Залуу хуульчдын салбарт сүүлийн гурван жилийн хугацаанд ажилласан нэг төлөөлөгч.

2.3.2. Австрали Улсын Хуульчдын холбоо болон Хуульчдын нийгэмлэгийн бүтэц, зохион байгуулалт

Зураг 6. Австрали Улсын Хуульчдын холбооны бүтэц



Австрали Улсын Хуульчдын холбооны ээлжит хурал нь холбооны эрх барих дээд байгууллага бөгөөд хурлыг Ерөнхийлөгч эсхүл Зөвлөл тухайн санхүүгийн жил дууссанаас хойш таван сарын дотор зарлан хуралдуулна. Жил бүрийн ээлжит хурал зарлан хуралдуулахын өмнө Зөвлөл нь өмнөх жилийн санхүүгийн тайлан, захирлуудын үйл

ажиллагааны тайлан болон аудитын дүгнэлтийг бэлтгэн, ээлжит хуралд оролцох гишүүдэд илгээнэ. Хуульчдын холбооны дүрэмд зааснаар⁹⁹ ээлжит хурал хуралдахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө гишүүдэд хурлын зар хүргүүлнэ.

Зөвлөл нь Холбоог удирдах байгууллага бөгөөд Захирлууд болон Өмгөөллийн сургалтын зөвлөлийн дарга (*Chair of the The Advocacy Training Council*), Нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн гишүүдийг санал өгөх эрхтэй болон эрхгүй гэж ангилна. Санал өгөх эрхтэй гишүүд нь Захирлууд байх ба санал өгөх эрхгүй гишүүд нь Өмгөөллийн сургалтын зөвлөлийн болон Нарийн бичгийн дарга нар байна.

Зөвлөл нь Австрали Улсын Хуульчдын холбооны дүрэмд зааснаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гишүүдийн заавал дагаж мөрдөх шинжтэй журам, шийдвэр гаргах;
- Бүх гишүүдийн Их хурал зарлан хуралдуулах, ээлжит бус Их хурал зарлан хуралдуулах;
- Санхүүгийн тайлан, захирлуудын тайлан, аудитын дүгнэлт бэлтгэх;
- Гишүүнд сахилгын сануулга өгөх, Холбооны гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах;
- Холбоог төлөөлж олон нийтэд мэдэгдэл гаргах;
- Дүрэмд зааснаар¹⁰⁰ Хороод байгуулах (гишүүнчлэл, үйл ажиллагааны чиглэл хариуцсан гэх мэт), тохиромжтой гэж үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхийг шилжүүлэх. Энэ хүрээнд Зөвлөл нь өдөр тутмын зохион байгуулалтын чиг үүргийг Холбооны албан тушаалтнуудад, өмгөөлөгчдийг хөгжүүлэх, дадлагажуулах, мэдээллээр хангахтай холбоотой чиг үүргийг Өмгөөллийн сургалтын зөвлөлд шилжүүлж болно.

⁹⁹ Хуульчдын холбооны дүрмийн 20 дугаар зүйл.

¹⁰⁰ Хуульчдын холбооны дүрмийн 39.3 дах хэсэг.

Сонгогддог албан тушаалтнууд: Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, хоёр Дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан менежер болон Өмгөөллийн сургалтын зөвлөлийн даргыг албан тушаалтнууд гэж нэрлэх бөгөөд Хуульчдын холбооны дүрэмд зааснаар¹⁰¹ эдгээр албан тушаалтныг жил бүрийн Их хурлаас сонгоно. Албан тушаалтанд холбооны гишүүнчлэл бүхий барристерууд эсхүл муж улсын Хуульчдын холбооноос нэр дэвшүүлсэн гишүүд сонгогдох эрхтэй.

Өмгөөллийн сургалтын зөвлөл (*The Advocacy Training Council*) нь Австрали Улсын Хуульчдын холбооны дүрэмд зааснаар дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Холбооны гишүүдэд зориулсан өмгөөллийн сургалтын сайн туршлага түгээх, өмгөөллийн сургалтын байгууллагуудын хоорондын харилцаа холбоог дэмжих зорилгоор форум зохион байгуулах;
- Өмгөөллийн дадлагажуулагчдыг илүү үр дүнтэй ажиллуулах зорилгоор тэдэнд туслах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, урамшуулах;
- Муж улсын Хуульчдын холбоод дотооддоо барристеруудын мэргэжлийн сургалт зохион байгуулах, сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжих, зөвлөгөө өгөх, урамшуулах;
- Өмгөөллийн сургалтын материалыг сайжруулах, сургагч багш нарыг материалаар хангах, сургалтын материалын номын сан бий болгох;
- Шүүх эрх мэдлийн бусад байгууллагын хүсэлтээр сургалт зохион байгуулахад туслалцаа үзүүлэх;
- Өмгөөллийн оюутнуудыг үнэлэх тогтолцоо бий болгохтой холбоотой муж улсын Хуульчдын холбоодтой хамтарч ажиллах;

Хороод нь гишүүдийнхээ туршлага, мэдлэгийг сайжруулах, мэргэжлээ үр дүнтэй төлөөлж, хуулийн шинэчлэл, эрх зүйн бодлогын асуудлыг


¹⁰¹ Хуульчдын холбооны дүрмийн 36 дугаар зүйл.

хэлэлцэх, сайжруулах зорилгоор байгуулагдана. Хороодыг нь бүс, муж улс, орон нутгийн Хуульчдын холбооны төлөөллөөс урилгаар бүрдүүлнэ. Хороо нь дараах чиг үүрэгтэй.

- Ерөнхийлөгч, албан тушаалтнууд, Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирлыг тухайлан мэргэшсэн салбарын зөвлөгөөгөөр хангах;
- Холбооноос санал өгөх хууль тогтоомжийг үнэлэх;
- Ерөнхийлөгчийн шийдвэрээр мэргэжсэн асуудлаараа төсөл боловсруулан Засгийн газар болон сонирхогч бусад талд хүргүүлэх;
- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй одоогийн болон хүлээгдэж буй үйл явдлын талаар Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгчид мэдээлэх.

Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн бүтэц, зохион байгуулалт

Зураг 7. Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн бүтэц



Ээлжит хурал нь Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгийн дүрмийн 10-г зааснаар Хуульчдын нийгэмлэгийн эрх барих дээд байгууллага бөгөөд тухайн санхүүгийн жил дууссанаас хойш таван сарын дотор зарлан хуралдуулна. Их хурлыг Зөвлөлийн шийдвэрээр эсхүл 250 солиситор гишүүний бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш Нарийн бичгийн дарга хоёр сарын дотор зохион байгуулна. Ээлжит хурлыг зохион байгуулах газар, хугацааг бичгээр хүсэлт гаргаснаас хойш 14 хоногийн дотор Зөвлөлөөс тогтоогоогүй тохиолдолд солиситор гишүүдийн сонгосон өдөр, газарт хуралдах ба энэ талаар Нарийн бичгийн дарга гишүүдэд мэдэгдэнэ. Дүрэмд зааснаар 25 солиситор гишүүн хуралд биечлэн ирсэн тохиолдолд хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.

Зөвлөл нь нийгэмлэгийг удирдах байгууллага бөгөөд Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байдаг. Ерөнхийлөгч, Ахлах дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, өмнөх жилийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан тохиолдолд тэдгээр нь албан тушаалын бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэлх хугацаанд Зөвлөлийн гишүүн байна. Дараах тохиолдолд Зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусгавар болно. Үүнд:

- Зөвлөлийн гишүүн Хуульчдын нийгэмлэгээс гарах хүсэлтээ бичгээр өгсөн;
- Зөвлөх нь Корпорацын тухай хуулийн дагуу албан тушаалаас чөлөөлөгдсөн эсхүл албан тушаал эрхлэхээ больсон;
- Зөвлөлийн гишүүн солиситор гишүүн байхаа больсон;
- Сэтгэцийн эрүүл мэндийн хувьд хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, ийм нөхцөл байдал гишүүнчлэлийн санхүүгийн жилд зургаа болон түүнээс дээш сар үргэлжилсэн;
- Зөвлөлийн гишүүн албан ёсны чөлөө авалгүйгээр Зөвлөлийн хуралд дараалан гурван удаа оролцоогүй;
- Зөвлөлийн гишүүн шууд болон шууд бусаар нийгэмлэгийн байгуулж буй гэрээ хэлцэлд хамааралтай ашиг сонирхол байгаа

эсхүл ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ Корпорацын тухай хуулиар шаардсанаар нотолж чадаагүй;

- Зөвлөлийн гишүүн нь Хуульчдын нийгэмлэгийн, нийгэмлэгт хамаарал бүхий компани болон удирдлагын талаас илүү хувийг Хуульчдын нийгэмлэгээс сонгодог, томилдог, нэр дэвшүүлдэг аливаа байгууллага, нэгдлийн захирлаас бусад албан тушаал хаших болсон;
- Ээлжит хурлын шийдвэрээр бүрэн эрхийг дуусгавар болгосон;
- Зөвлөлийн гишүүн нас барсан.

Зөвлөлийн гишүүний сул байгаа орон тоог дараах байдлаар нөхнө. Үүнд:

- Зөвлөл сул байгаа орон тоог нөхөхөөр солиситор гишүүнийг томилж болно;
- Сул орон тоог нөхөхөөр томилогдсон гишүүн нь томилогдсон өдрөөс дараагийн Зөвлөлийн гишүүний сонгуулийн үр дүнг зарлах хүртэлх хугацаанд Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;
- Зөвлөлийн гишүүний эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн тохиолдолд сонгуулиар дараагийн өндөр санал авсан нэр дэвшигчийг Зөвлөлийн гишүүний үлдсэн хугацаагаар сонгоно;
- Зөвлөлийн гишүүний бүрэн эрх гурав дахь жил дээрээ хүчингүй болсон эсхүл түдгэлзсэн тохиолдолд сул орон тоог нөхөхөөр томилогдсон гишүүн нь дараагийн сонгуулийн үр дүнг зарлах хүртэлх хугацаанд Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- Зөвлөлийн гишүүний сул орон тоог зөвхөн тухайн Зөвлөлийн гишүүнээр нөхнө. Хотын зөвлөлийн гишүүний сул орон тоог Хотын зөвлөлийн гишүүнээр, Байгууллагын зөвлөлийн гишүүнийг Байгууллагын зөвлөлийн гишүүнээр гэх мэт.

Зөвлөл нь тодорхой ашиг сонирхлыг хамгаалахаар “хороо” байгуулан, өөрийн эрх мэдэл, чиг үүргийг шилжүүлж болно. Хороодын жагсаалтыг жил бүр гишүүдийн санал асуулгаар гаргана. 2021 оны байдлаар Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэг нь 27 чиглэлийн хороодтой¹⁰² байна.


Дүүргийн хуульчдын нийгэмлэг¹⁰³

Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгт хотын, хотын захын, орон нутгийн Хуульчдын нийгэмлэгүүд мөн хамаардаг. Үүнд:

- Хотын Хуульчдын нийгэмлэг - 1¹⁰⁴;
- Хотын захын Хуульчдын нийгэмлэг - 8;
- Орон нутгийн Хуульчдын нийгэмлэг - 20.

2.3.3. Япон Улсын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт

Зураг 8. Япон Улсын Хуульчдын холбооны бүтэц



¹⁰² Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгийн веб хуудас. <https://www.lawsociety.com.au>, Current committee list | The Law Society of NSW, сүүлд хандсан огноо: 2021.11.08.

¹⁰³ Шинэ Өмнөд Уэльсийн Хуульчдын нийгэмлэгийн дүрмийн 16.3 дугаар зүйл. <https://www.lawsociety.com.au/NSW Constitution>

¹⁰⁴ City of Sydney Law Society Inc.

Нэгдсэн хурал нь Холбооны шийдвэр гаргах дээд байгууллага¹⁰⁵ байна. Ээлжит болон ээлжит бус нэгдсэн хурлаар бүрэн эрхийн хүрээний асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Ээлжит хуралдааныг жил бүрийн зургаадугаар сард, ээлжит бус хуралдааныг тухай бүр хуралдуулна. Нэгдсэн хурлын ээлжит хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

- Дансны зөвшөөрөл, төсөв батлах;
- Холбооны дүрэм болон бусад дүрэм, журам батлах, өөрчлөх;
- Мэргэшлийн шалгалтын зөвлөл, Сахилгын хороо, Сахилгын хэрэгжилтийн хороо, Сахилгын хяналтын зөвлөлийн гишүүд болон нөөц гишүүдийг томилох;
- Хууль, дүрмийн заалтын дагуу ээлжит хуралдаанд хэлэлцүүлэх асуудал;
- Захирагчдын зөвлөл эсхүл Төлөөлөгчдийн танхимаас ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудал.

Нэгдсэн хуралд Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй Хуульчдын холбоо болон өмгөөлөгч бүр нэг саналын эрхтэй оролцоно. Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани саналын эрх эдлэхгүй. Ээлжит хуралдаанд саналын эрхтэй 5,000-аас дээш гишүүн ирснээр ирц бүрдсэнд тооцно. Нэгдсэн хурлын ээлжит бус хуралдааныг Төлөөлөгчдийн танхимын арваас дээш төлөөлөгч эсхүл Хуульчдын холбооны 300-гаас дээш гишүүний гаргасан шаардлагыг Ерөнхийлөгч хүлээн авч Захирагчдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, хуралдаан хийснээс хойш 14 хоногийн дотор ээлжит бус хуралдааныг хуралдуулах ажиллагааг эхлүүлдэг.

Төлөөлөгчдийн танхим нь Холбооны удирдах байгууллага ба дараах асуудлыг хариуцан шийдвэрлэдэг. Үүнд:

- Хуульчдын холбооны төсөв батлах;

¹⁰⁵ Articles of Association of Japan of Bar Associations.
<https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/articles.pdf>

- Хуульчдын холбооны үндсэн дүрэм болон бусад дүрэм, журам батлах, өөрчлөлт оруулах;
- Дэд ерөнхийлөгчид, Удирдах зөвлөлийн гишүүд, аудиторуудыг сонгох;
- Хяналтын хорооны гишүүдийг сонгох;
- Хуульчдын холбооны үйл ажиллагааг дүрэмд нийцүүлэх;
- Нэгдсэн хурлын ээлжит хуралдаанаар тухайлан шийдвэрлэхээр заасан асуудлууд;
- Удирдах зөвлөлөөр шийдвэрлэхээр зааснаас бусад асуудал.

Төлөөлөгчдийн танхим бүрэлдсэн анхны хуралдаанаар Танхимын дарга, дэд даргыг сонгох ба төлөөлөгч бүр нэг саналын эрхтэй байна.

Удирдах зөвлөлийн хурлаар Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд Хуульчдын холбооны дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- Хуульчдын холбооны удирдлагатай холбогдох;
- Хуульчдын холбооны дүрэм батлах, Хуульчдын холбоо байгуулахыг баталгаажуулах;
- Гишүүн Хуульчдын холбоотой зөвлөлдөх, тодруулга авах;
- Өмгөөлөгчдийг бүртгэх, бүртгэлийн нэрийн жагсаалтыг өөрчлөх, бүртгэлийг хүчингүй болгох;
- Өмгөөлөгчийн бүртгэлд тавигдах шаардлагыг тодорхойлох;
- Өмгөөлөгч, хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх компаниудад сахилгын шийтгэл ногдуулах;
- Зөвшөөрөгдсөн гадаад өмгөөлөгчийн хууль ёсны үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх, цуцлах санал өгөх;
- Бүртгэлтэй гадаад улсын хуульч байх эрх бүхий этгээдийг зөвшөөрөх, эрхийг нь цуцлах;

- Зөвшөөрөгдсөн гадаадын хуульчдыг бүртгэх, бүртгэлийг өөрчлөх, хүчингүй болгох;
- Бүртгэгдсэн гадаадын хуульч, бүртгэгдсэн гадаадын хуулийн мэргэжлийн компаниудад сахилгын арга хэмжээ авах;
- Хуульчдын холбоонд хууль зүйн дагалдан бэлтгэх, сургах;
- Дээд шүүхэд өгсөн тайлан, Засгийн газар, олон нийтийн байгууллагуудын хяналт шалгалтын асуудал;
- Захирагчдын зөвлөлийн хэлэлцэх бусад асуудал;
- Ерөнхийлөгчөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Захирагчдын зөвлөл нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, захирагчдаас бүрдэнэ. Тус зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэдэг. Үүнд:

- Хуульчдын холбооны удирдлагатай холбоотой чухал асуудлууд;
- Нэгдсэн хурал болон Төлөөлөгчдийн танхимын хуралдаанд хэлэлцэх асуудал;
- Журам, зохицуулалт батлах, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудал;
- Нэгдсэн хурлын тогтоолыг хүчингүй болгох тухай асуудал;
- Хүндэт гишүүдтэй холбогдох асуудал;
- Нэгдсэн хурал эсвэл Төлөөлөгчдийн танхимаас Захирагчдын зөвлөлд шилжүүлсэн асуудал;
- Ерөнхийлөгчөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Ерөнхийлөгч нь бүх өмгөөлөгч гишүүний дундаас сонгогдох ба Хуульчдын холбоог төлөөлөн, үйл ажиллагаанд хяналт тавьж, Хуульчдын холбооны хөрөнгийг удирдах эрхтэй байна. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байна. Ерөнхийлөгч Төлөөлөгчдийн танхимын ээлжит хурлыг зарлах эрхтэй.

Дэд ерөнхийлөгч, захирагч болон аудиторыг Төлөөлөгчдийн танхим Хуульчдын холбооны гишүүдээс жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор томилно. Хуульчдын холбоо бүрээс хоёр хүртэлх Дэд ерөнхийлөгч томилох боломжтой. Удирдах зөвлөлийн гишүүдийг Захирагчдаас сонгоно.


- 15 Дэд ерөнхийлөгч (хоёроос дээш эмэгтэй гишүүдээс сонгогдсон байна);
- 71 захирагч (Удирдах зөвлөлөөс зарим захирагчдыг томилж болно);
- Таван аудитор Хуульчдын холбооны дансанд аудит хийх зэргээр тус тусын чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллана.

Ерөнхийлөгчөөс бусад албан тушаалтны бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдөр томилогдсоноор бүрэн эрхийн хугацаа нь эхэлнэ.

2.3.4. Постсоциалист орнуудын Хуульчдын холбоодын бүтэц, зохион байгуулалт

ОХУ-ын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт

Зураг 9. Оросын Хуульчдын холбооны бүтэц



Холбооны Их хурал нь эрх барих дээд байгууллага бөгөөд Холбооны Тэргүүлэгчдээс товлосноор гурван жил тутамд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Холбооны Ерөнхийлөгчийн санаачилгаар эсхүл Холбооны хяналт-шалгалтын байгууллагын шаардлагаар эсхүл бүс нутгийн гуравны нэгээс доошгүй гишүүдийн шаардлагаар ээлжит бус хурлыг товлон. Холбооны Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

- Холбооны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, холбооны хөрөнгийг бүртгэх, ашиглах зарчмыг тогтоох;
- Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Холбооны бүтцийн байгууллагыг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх асуудлаар шийдвэр гаргах;
- Холбооны гишүүнчлэлийн болон эд хөрөнгийн хураамжийн хэмжээг тогтоох;
- Холбооны гишүүнээр элсэх болон гишүүнчлэлийг хүчингүй болгох журмыг тодорхойлох;
- Хамтын удирдлага бүхий Удирдах зөвлөлийн гишүүдийг Хурлын Тэргүүлэгчдээс гурван жилийн хугацаатайгаар сонгох эсхүл хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг хэлэлцэх;
- Холбооны Ерөнхийлөгч, Тэргүүлэгч, Хяналт-шалгалтын төв хороо, Нарийн бичгийн даргыг сонгох эсхүл хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг шийдвэрлэх;
- Холбооны Удирдах зөвлөл болон Хяналт-шалгалтын хорооны үйл ажиллагааны тайланг батлах;
- Холбооны үйл ажиллагааны жилийн болон санхүүгийн тайланг батлах;
- Татан буугдах хорооны талаар хэлэлцэж, татан буулгах тохиолдолд хорооны санхүүгийн тайланг батлах;

- Аудитын компанийг сонгох эсхүл аудиторыг томилон ажиллуулах шийдвэр гаргах.

Холбооны Их хуралд бүсийн салбарын төлөөлөгчдийн тавиас дээш хувь төлөөлж оролцсоноор Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно. Хурлын төлөөлөгчдөд Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Тэргүүлэгчид, Холбооны Удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Хяналт-шалгалтын хорооны дарга, гишүүдийг хамруулдаг. Хурлын шийдвэрийг нээлттэй эсхүл нууц санал хураалтаар хуралд оролцсон нийт гишүүний ердийн олонхын саналаар шийдвэрлэдэг.

Холбооны Тэргүүлэгчдийг дүрмийн 12 дугаар зүйлд зааснаар Холбооны Их хурлаас гурван жилийн хугацаагаар гишүүдийн санал хураалтаар сонгоно. Холбооны Тэргүүлэгчдийн тоог Их хурал батална. Холбооны Тэргүүлэгчид нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга болон Тэргүүлэгчдийн бусад гишүүнээс бүрдэнэ. Холбооны Тэргүүлэгчдийн хурал нь зургаан сар тутамд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хурлын товыг Ерөнхийлөгч тогтооно. Тэргүүлэгчид нь дараах бүрэн эрхтэй. Үүнд:

- Холбооны Төлөөлөн удирдах зөвлөл (*Попечительский совет Организации*)-ийг бүрдүүлэх;
- Холбооны Тэргүүлэгчдийн товчоо (*Бюро Президиума*)-ны гишүүдийг батлах, мөн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох асуудлыг шийдвэрлэх;
- Ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг тогтоох;
- Холбооны Их хурлын өмнө үйл ажиллагаагаа тайлагнах;
- Холбооны шагналыг батлах;
- Холбооны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг батлах;
- Хууль эрх зүйн тулгамдсан асуудлаарх Холбооны нэгдсэн байр суурийг илэрхийлэх.

Холбооны Тэргүүлэгчдийн товчоо нь зайлшгүй тохиолдолд Ерөнхийлөгчийн товлосноор хуралдаж, дараах асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

- Эрх зүйн хэм хэмжээний актын төсөл боловсруулж, Их хурал болон Тэргүүлэгчдэд танилцуулах;
- Холбооны Их хурал, Тэргүүлэгчдийн баталсан эрх зүйн хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих;
- Олон нийтийн бусад байгууллага болон төрийн байгууллагатай хамтын ажиллагааны хэрэгжилтийг хангах;
- Тэргүүлэгчдийн тодорхойлсон чиглэлийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулах.

Холбооны төлөөлөн удирдах зөвлөл нь дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх гол үүрэг хүлээнэ.¹⁰⁶ Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон олон нийтийн байгууллагын албан хаагч, эрдэмтэд, бизнесийн байгууллагын төлөөлөгчид, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх иргэний нийгмийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төлөөлөгчид байна. Холбоо нь дүрэмд заасан зорилгоо биелүүлэн ажиллаж буй эсэхэд Төлөөлөн удирдах зөвлөл ерөнхий хяналт тавина.

Холбооны Ерөнхийлөгчийг Их хурлаас Тэргүүлэгчдийн саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Олон улсын байгууллага, ашгийн болон ашгийн бус хуулийн этгээд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн байгууллагын өмнө Холбооны хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлж, холбоог итгэмжлэлгүйгээр төлөөлнө;
- Холбооны Их хурлыг даргалах бөгөөд Тэргүүлэгчдийг удирдана;
- Холбооны Их хурал болон Тэргүүлэгчдийн өмнө үйл ажиллагаагаа тайлагнана.

¹⁰⁶ Оросын Хуульчдын холбооны дүрмийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://alrf.ru>

Холбооны зөвлөлийн дарга, гишүүдийг Их хурлын гишүүдийн саналаар гурван жилийн хугацаатайгаар сонгоно. Зөвлөл нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Их хурлын өмнө үйл ажиллагаагаа тайлагнана;
- Их хуралд зориулж жилийн санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн тайланг бэлтгэнэ;
- Их хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангаж, гүйцэтгэлд хяналт тавина;
- Бүсийн болон орон нутгийн салбар байгуулах эсхүл татан буулгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ;
- Холбооны Тамгын газрын дарга буюу Гүйцэтгэх захирлын жилийн тайлантай танилцана;
- Холбооны төсвийн төслийг баталж, гүйцэтгэлийг хангана;
- Холбооны санхүүгийн төлөвлөгөөг баталж, нэмэлт өөрчлөлт оруулна;
- Их хуралд оролцвол зохих төлөөлөгчдийн тоог тодорхойлж, хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулна;
- Холбооны үйл ажиллагаанд холбогдох журам батална.

Зөвлөлийн дарга нь дүрэмд зааснаар¹⁰⁷ дараах бүрэн эрх эдэлнэ. Үүнд:

- Байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлж, итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
- Холбооны дүрэмд заасны дагуу хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр батлах;
- Хууль эрх зүйн тулгамдсан асуудлаар холбооны байр суурийг илэрхийлэх.

¹⁰⁷ Холбооны дүрмийн 14 дүгээр зүйлийн 6.
<https://alrf.ru/upload>

Холбооны Тамгын газар нь Их хурал, Тэргүүлэгчид, Удирдах зөвлөл, Хяналт-шалгалтын төв хороонд хамаарахаас бусад асуудлыг хариуцан шийдвэрлэдэг. Холбооны дүрмийн 20 дугаар зүйлд зааснаар Тамгын газар нь зохион байгуулалтын, эрх зүйн, материал-техникийн, баримт бичгийн, мэдээллийн болон холбооны бусад үйл ажиллагааг хангаж ажиллана. Холбооны Тамгын газрын дарга буюу Гүйцэтгэх захирлыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлөөс томилох бөгөөд дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

- Холбооны төсвийн төслийг боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах;
- Холбооны гишүүдийн бүртгэл хөтлөх;
- Их хурал, Тэргүүлэгчид, Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;
- Холбооноос зохион байгуулах үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр боловсруулах;
- Холбооны Тамгын газрын ажилтнуудад хамаарах хөдөлмөрийн харилцааг зохицуулах;
- Санхүүгийн баримт дээр нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг хэрэгжүүлэх.

Холбооны хяналт-шалгалтын төв хорооны дарга болон гишүүдийг Их хурлаас гурван жилийн хугацаатайгаар сонгоно.¹⁰⁸ Холбооны санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайлангийн гүйцэтгэлд хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаандаа мэргэжилтнийг татан оролцуулна. Хяналтын үйл ажиллагаа нь гурван жил тутамд нэгээс доошгүй удаа зохион байгуулагдана. Хяналт-шалгалтын хорооны гишүүн нь Холбооны бусад газар, нэгжийн гишүүн байхыг хориглоно.

Бүсийн зөвлөл: Холбооны дүрмээс гадна 2010 онд батлагдсан ОХУ-ын Хуульчдын холбооны Бүсийн зөвлөлийн ерөнхий дүрмээр Бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулдаг. Холбооны дүрмийн


¹⁰⁸ Холбооны дүрмийн 19-р зүйл.
<https://alrf.ru/upload>

23 дугаар зүйлд заасны дагуу ОХУ-ын бүсүүдэд хуулийн этгээдийн эрхгүй боловч зохицуулалтын болон зөвлөх чиг үүрэг бүхий Бүсийн зөвлөл байгуулна. Бүсийн зөвлөлийн дарга болон бүтэц, үйл ажиллагааны журмыг холбооны Ерөнхийлөгч батална.

Литва Улсын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт

Литва Улсын Хуульчдын холбооны тухай хуулийн 59.1 дэх хэсэгт заасны дагуу Хуульчдын холбоо нь дараах бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

Зураг 10. Литва Улсын Хуульчдын холбооны бүтэц



Хуульд тусгайлан заагаагүй бол Хуульчдын холбооны бүтцэд хамаарах байгууллагаас гаргасан аль ч шийдвэртэй холбоотойгоор тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш нэг сарын дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.¹⁰⁹

Их хурал¹¹⁰ нь холбооны эрх барих дээд байгууллага байна. Хуульч бүр хуралд оролцох үүрэгтэй ба хурлыг жилд нэг удаа зохион байгуулна. Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

¹⁰⁹ Хуульчдын холбооны тухай хуулийн 58.2. IX-2066 Law on the Bar

¹¹⁰ Литва Улсын Хуульчдын холбооны веб сайт.

<https://www.advokatura.lt/visuotinis-susirinkimas>, сүүлд хандсан огноо: 2021.11.08.

Холбооны бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох чиглэлээр:

- Зөвлөл болон Хяналтын хорооны бүтэц, орон тоог тодорхойлох;
- Зөвлөлийн дарга болон гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд, Өмгөөлөгчдийн нэрэмжит шүүхийн гурван гишүүнийг томилох эсхүл Холбооны дүрэмд заасан үндэслэлээр эргүүлэн татах.

Холбооны үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр:

- Зөвлөлийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайланг батлах;
- Хяналтын хорооны жилийн тайлантай танилцах;
- Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн шийдвэрийг хүчингүй болгох;
- Холбооны ажилчдын орон тоог батлах;

Холбоо болон гишүүдийн үйл ажиллагаа, санхүүгийн харилцааг зохицуулах чиглэлээр:

- Холбооны дүрэм болон хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Холбооны гишүүдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах журам баталж, өөрчлөх;
- Хуульч болон хуульчийн туслахад ногдох гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг батлах.

Хуульчдын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр:

- Хуульчдын олон улсын болон мэргэжлийн бусад байгууллагад нэгдэх эсэхийг шийдвэрлэх;
- Хуульчийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг шийдвэрлэх журам батлах.

*Холбооны Ерөнхийлөгч*¹¹¹ нь Их хурлаас дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогддог. Ерөнхийлөгч нь Холбооны нэрийн өмнөөс үйлдэл хийх бөгөөд гуравдагч талын өмнө Холбоог төлөөлнө.

*Гүйцэтгэх байгууллага*¹¹² нь Холбооны Их хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж, дүрэмд заасан бүрэн эрхийг Зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн гишүүн нь арваас доошгүй жил хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн байх бөгөөд тухайн шаардлага хангасан Холбооны гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх байгууллага нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Хуульчдын бүртгэлийг хадгалах;
- Хуульчийн гишүүнчлэлийн эрхийг дуусгавар болгох;
- Нийтийн хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангах, хяналт тавих;
- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хуульчдын хууль ёсны ашиг сонирхлыг шүүх, төрийн бусад байгууллагын өмнө төлөөлөх;
- Холбооны гишүүдэд сахилгын шийтгэл оногдуулах шийдвэр гаргах.

Аудитын хороо холбооны хяналтын чиг үүрэг болон холбооны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ. Аудитын хорооны гишүүдийг дөрвөн жилийн хугацаатайгаар Их хурлаас сонгоно. Хороо нь гурван гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь хуульчаар таваас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

Өмгөөлөгчдийн нэрэмжит шүүх нь Холбооны гишүүний үйл ажиллагаанд холбогдох гомдол хүлээн авч, хянан шийдвэрлэх чиг үүрэг

¹¹¹ World Bank Document, Comparative analysis of Bar Associations and Law societies in Select European Jurisdictions, 2017.

<https://openknowledge.worldbank.org>

¹¹² *Ibid*, <https://www.advokatura.lt/advokatu-taryba/>

хэрэгжүүлнэ. Литва Улсын Хуульчдын холбооноос баталсан журмын дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг шийдвэрлэнэ. Өмгөөлөгчдийн шүүх нь таван гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүд нь хууль зүйн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан байх шаардлага тавигддаг. Нийт гишүүний гурвыг Өмгөөлөгчдийн Их хурлаас сонгодог бол үлдсэн хоёрыг Бүгд Найрамдах Литва Улсын Хууль зүйн яамнаас томилдог. Шүүх хурлын зохион байгуулалт хаалттай хэлбэрээр явагдана. Гишүүнд дараах сахилгын хариуцлага ногдуулна. Үүнд:

- Тэмдэглэл үйлдэж анхааруулах;
- Сануулах;
- Нээлттэй сануулах;
- Хуульчийн туслахын бүртгэлийг хүчингүй болгох;
- Шүүхэд төлөөлөх эрхийг нь хүчингүй болгож, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох.

Өмгөөлөгч нь шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Вильнюсийн тойргийн Өмгөөлөгчийн нэрэмжит шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Хороо нь зөвлөхийн тогтоосон зорилгын биелэлтийг хангаж, Холбооны гишүүдэд тулгамдаж буй асуудлаар оновчтой шийдвэр гаргах, хуульчдын оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Нийт 13 хороотой. Хороод нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:


- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд хуульчид тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах;
- Хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн нөхцөл байдлыг анхааран судалж, хууль зүйн өөрчлөлттэй холбоотой асуудлаар санал боловсруулан Холбоонд хүргүүлэх;
- Зөвлөлөөс тогтоосон зорилтыг хэрэгжүүлэх;

Тамгын газар нь Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах бөгөөд хуульч, хуульчийн туслахад үйлчилгээ үзүүлнэ. Тамгын газрыг Холбооны Ерөнхийлөгч удирдана. Холбооны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, байгууллагын хуульчид, нягтлан бодогч, зөвлөх, төлөөлөгч болон олон нийттэй харилцах зөвлөхүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Ерөнхийлөгч нь хууль зүйн мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан туршлагатай хуульч байна.

Беларусь Улсын Хуульчдын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

Беларусь Улсын Хуульчдын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалтыг Зөвлөлийн дүрмийн 4 дүгээр бүлэгт дараах байдлаар тодорхойлжээ (Зураг 11).

Зураг 11. Беларусь Улсын Хуульчдын зөвлөлийн бүтэц¹¹³



¹¹³ Устав общественного объединения “Белорусский Республиканский Союз Юристов”.
<https://union.by>, Устав - Союз юристов Беларуси

Их хурал нь Хуульчдын зөвлөлийн эрх барих дээд байгууллага бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Их хурлын зохион байгуулалтад холбогдох асуудлыг шийдвэрлэж, хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох;
- Холбооны дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Холбооны Зөвлөлийн гишүүд, Хяналтын хорооны дарга, гишүүдийг таван жилээр сонгох;
- Холбооны хөтөлбөрийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Холбооны зөвлөл болон Хяналтын комиссын тайланг сонсож, батлах;
- Холбооны бүтцийн бусад байгууллагын шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох
- Холбоог татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэх.

Төв зөвлөл нь Холбоог удирдах байнгын үйл ажиллагаатай байгууллага байна.

- Хуульчдын холбооноос гарсан шийдвэрийн биелэлтийг хангах ажил зохион байгуулах;
- Хуульчдын нэгдсэн зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- Их хурал товлож, бэлтгэл ажлыг хангах арга хэмжээ зохион байгуулах;
- Хуульчдын нэгдсэн зөвлөлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хуульчдын нэгдсэн зөвлөлийн бүтцийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

- Хуульчдын бүтцийн байгууллагуудыг байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулах;
- Их хурлаар шийдвэрлэхээр зааснаас бусад Хуульчдын нэгдсэн зөвлөлийн үндсэн чиг үүрэгт холбогдох асуудлыг зохицуулах.

Төв зөвлөлийн Тэргүүлэгчид нь Холбооны төв зөвлөл болон Их хурлаас тогтоосон ажлыг хариуцан зохион байгуулах үүрэгтэй. Тэргүүлэгчид нь Холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Бүсийн болон Минск хотын салбар Хуульчдын зөвлөлийн Ерөнхийлөгчид болон Гүйцэтгэх захирлаас бүрддэг. Төв зөвлөлийн дэргэд байнгын ажиллагаатай чиг үүргийн хороод үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Олон улсын харилцаа хариуцсан хороо;
- Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан хороо;
- Хууль, эрх зүйн хэмжээний акт бүтээх, боловсронгуй болгох асуудал хариуцсан хороо;
- Олон талт маргаан шийдвэрлэх арга замыг хөгжүүлэх болон спортын эрх зүй хариуцсан хороо;
- Мэдээллийн хороо.

Хяналтын төв хорооны гишүүдийг Хуульчдын холбооны Их хурлаар сонгох бөгөөд хороо нь санхүүгийн хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх захиргаа нь Их хурал, Төв зөвлөл болон Төв зөвлөлийн Тэргүүлэгчид, Ерөнхийлөгчөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг бөгөөд захиргааны чиг үүрэг гүйцэтгэнэ.

Улс орнуудын харьцуулсан судалгааны тойм

Монгол Улсын болон дээр харьцуулан судалсан улс орнуудын Хуульчдын холбооны бүтцийг Хүснэгт 5-д нэгтгэн оруулав.

Хүснэгт 5. Улс орнуудын Хуульчдын холбоодын бүтэц

Бүтэц, зохион байгуулалт	МХХ	АНУ-ын Хуульчдын холбоо	Австрали Улсын Хуульчдын холбоо	Япон Улсын Хуульчдын холбоо	ОХУ, Литва, Беларусь ¹⁴
Эрх барих дээд байгууллага	Их хурал	Төлөөлөгчдийн танхим	Ээлжит хурал	Нэгдсэн хурал	Их хурал
Удирдах байгууллага	Удирдах зөвлөл	Удирдах зөвлөл	Зөвлөл	Төлөөлөгчдийн танхим	Зөвлөл, Тэргүүлэгчид
Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч	Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч	Ерөнхийлөгч
Гүйцэтгэх байгууллага	Тамгын газар	Сонгогддог бусад албан тушаалтнууд	Захирлууд, албан тушаалтнууд Өмгөөллийн сургалтын зөвлөлийн дарга	Удирдах зөвлөл, Захирагчдын зөвлөл	Тамгын газар

¹⁴ Зөвхөн төстэй бүтцийн нэгжүүдийг оруулав. Иймд тухайн улсын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтын хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Хяналтын зөвлөл	Хяналтын зөвлөл	Санхүү хариуцсан албан тушаалтан	Хяналтын хороо, аудиторрууд	Хяналт/ аудитын хороо
Хороод	Чиг үүргийн, сайн дурын хороод	Санхүү хариуцсан болон тусгай хороод	Хороод	Хороод
Орон нутгийн болон бүс нутгийн холбоод	Салбар	Хэсэг, салбар	Салбар	Бүс, орон нутгийн салбар

Эрх барих дээд байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлаар хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын дүрмийг батлах, сонгогддог албан тушаалтнуудыг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, гишүүнчлэлийн хураамжийг батлах нийтлэг бүрэн эрх хэрэгжүүлдэг. АНУ болон Австрали Улсын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлан тодорхойлсон сайн туршлагаас үзвэл сонгогдсон албан тушаалтан цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд сул орон тоонд албан тушаалтан сонгох асуудлыг ойлгомжтой байдлаар зохицуулсан байна. Сул орон тоонд албан тушаалтан шалгаруулах журмыг тодорхой болгосноор холбооны үйл ажиллагаа тогтвортой, хэвийн, тасралтгүй үргэлжлэх боломж бүрдүүлэх ач холбогдолтой тул МХХ-ны бүтэц, зохион байгуулалтын онцлогт тулгуурлан сул орон тоонд холбогдох асуудлыг нарийвчлан тогтоох шаардлагатай юм. Түүнчлэн Хуульчдын холбоо нь чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлж байна. Хуульд эсхүл дүрэмд заавал байгуулах шаардлагатай хороог шууд тодорхойлдог. Тухайлбал, Хуульчийн мэргэжлийн хариуцлагын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулах шаардлага зайлшгүй үүсдэг тул тус хороог удирдах байгууллагаас байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байна. МХХ-ны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны эрх зүйн орчныг хуулиар хүчингүй болгосон тул холбоонд бүртгэлтэй “бусад хуульч”-ийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг шийдвэрлэх чиг үүргийн хороог дахин байгуулах зүй ёсны шаардлага үүсэж байна.

2.4. ХУУЛЬЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫГ СОНГОХ ТОГТОЛЦОО (АНУ, АВСТРАЛИ УЛС, ЯПОН УЛС, ОХУ)

2.4.1. Эрх барих дээд байгууллага дахь төлөөлөгчийг сонгох

Хуульчдын холбооны эрх барих дээд байгууллага болох Хурал буюу Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчдийг сонгох байдлыг Хүснэгт 6-д харуулав.

*Хүснэгт 6. Гадаад орнуудын Хуульчдын холбоодын
Хурлын төлөөлөгчийг сонгож буй байдал*

Улс орнууд	Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх, сонгох журам
АНУ-ын Хуульчдын холбоо	<ul style="list-style-type: none"> - Муж улсын болон орон нутгийн Хуульчдын холбооноос төлөөлөгчид нэр дэвшүүлнэ. - Муж улсын Хуульчдын холбооноос төлөөлөгчийг нэр дэвшүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 4000-аас олон гишүүнтэй бол нэг төлөөлөгч байх ба 4000-аас илүү олон гишүүний 2500 гишүүн тутамд нэг төлөөлөгч нэмэгдэнэ. - 14,000-20,000 гишүүнтэй бол нийт тав хүртэлх төлөөлөгч байх; - 20,000-аас олон гишүүнтэй бол зургаа хүртэлх төлөөлөгч байх; - Орон нутгийн Хуульчдын холбоо 2,000-аас олон гишүүнтэй бол нэг төлөөлөгч нэр дэвшүүлнэ. - Муж улсын болон орон нутгийн Хуульчдын холбоо нь нэр дэвшүүлж буй төлөөлөгчдийг тогтоосон журмын дагуу сонгодог. - Муж улс, орон нутгийн болон салбарын Хуульчдын холбооны төлөөлөгчдийн мэдээллийг үндэслэн, дараагийн ээлжит хуралдаанаар шинэ төлөөлөгчдийг баталгаажуулах эсэхийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тодорхойлдог.
Австрали Улсын Хуульчдын холбоо	<ul style="list-style-type: none"> - Зөвхөн муж улс, бүс нутгийн Хуульчдын холбоод өөрсдийн төлөөлөгчийг оролцуулж, санал өгөх эрхтэй. - Холбоо бүр нэг саналын эрхтэй.
Австрали Улсын Шинэ Өмнөд Уэлс муж улсын Хуульчдын нийгэмлэг	<ul style="list-style-type: none"> - Хуралд оролцох төлөөлөгчийг сонгодоггүй. - Нийгэмлэгийн гишүүн бүр Хуралд оролцох эрхтэй. Тус Нийгэмлэгийн дүрэмд зааснаар 25 солиситор гишүүн Хуралд биечлэн оролцохоор ирсэн тохиолдолд Хурлын ирц бүрдсэнд тооцно.

Хүснэгт 6-гийн үргэлжлэл

<p>Япон Улсын Хуульчдын холбоо</p>	<ul style="list-style-type: none"> - Хуралд оролцох төлөөлөгчийг сонгодоггүй. - Нэгдсэн хуралд Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй Холбоо болон гишүүн хуульч бүр нэг саналын эрхтэй оролцоно. - Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компани саналын эрхгүй. - Ээлжит хуралдаанд саналын эрхтэй 5,000-аас дээш гишүүн оролцсоноор ирц бүрдсэнд тооцно.
<p>ОХУ-ын Хуульчдын холбоо</p>	<ul style="list-style-type: none"> - Холбооны бүсийн салбарын ээлжит бус хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналыг авсан хуульч Их хуралд төлөөлөгчөөр оролцох эрхтэй. - Дээрхээс гадна Холбооны Ерөнхийлөгч, Дэд дарга, Холбооны Тэргүүлэгчид, ТУЗ-ийн дарга, гишүүд, Хяналт-шалгалтын хорооны дарга төлөөлөгчөөр оролцоно.

Судалгаанаас үзэхэд Хуульчдын холбооны Хурлын төлөөлөгчдийн нийт тоог хуулиар эсхүл дүрмээр хатуу тогтоох бус, гишүүнчлэлийн төрөл, гишүүдийн тоонд үндэслэн хувь тэнцүүлэн тогтоох эсхүл нийт гишүүний оролцоог бүрэн хангах үүднээс хуралд оролцох боломжийг гишүүн бүрд олгох гэсэн хоёр аргаар Их хурлыг зохион байгуулж, хууль болон дүрмээр тодорхойлсон асуудлыг шийдвэрлэж байна. МХХ нь хувь тэнцүүлэх замаар Их хурлын төлөөлөгчдийн тоог тодорхойлж, төлөөлөгчийг нэр дэвшүүлэн, сонгох арга зам баримталж байгаа бөгөөд уг арга нь шийдвэр гаргалтад нийт хуульч оролцохгүй байх, гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалсан шийдвэр гарахгүй байх, нэгдмэл бус, хуваагдмал байр суурь бий болгох зэрэг сөрөг үр дагавартай. Иймд хуулиар эсхүл дүрмээр төлөөлөгчдийн тоог тогтоох арга замаас зайлсхийн, нийт гишүүний оролцоог хангах шийдлийг сонгон хэрэгжүүлэх боломжтой.

2.4.2. Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүд болон Ерөнхийлөгчийг сонгох

Хуульчдын холбооны удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх, гишүүдийн дагаж мөрдөх журам, шийдвэрийг гаргах, эрх барих дээд байгууллагын хурлыг зарлан хуралдуулах эрхийг АНУ, Австрали,

постсоциалист орнуудын хувьд “Удирдах зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх), Япон Улсад “Төлөөлөгчдийн танхим” хэрэгжүүлдэг.

АНУ-ын Хуульчдын холбооны Төлөөлөгчдийн танхимын хурлаас Удирдах зөвлөлийн гишүүд болон Ерөнхийлөгчийг сонгодог. Хуульд зааснаас бусад тохиолдолд Удирдах зөвлөл нь 43 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн бүрэн эрхийн хугацаа гурван жил, хуулийн оюутан гишүүний бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба хугацааг гишүүнээр сонгосон жилийн ээлжит хурлаас эхлэн тоолно. Зөвлөлийн гишүүнийг улируулан сонгохгүй. Зөвлөлийн гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй тухайн тойрог/дүүрэгт хамаарах бусад гишүүнээс Холбооны Төлөөлөгчдийн танхим сонгож сул орон тоог нөхдөг.

Япон Улсын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь Холбооны гишүүдээс сонгогддог. Нийт гишүүний санал хураалтаар хамгийн өндөр санал авсан буюу санал өгсөн нийт гишүүний гуравны нэгээс илүү санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байна. Хуульчдын холбооны Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчдийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор сонгосон байх ба дараах аргаар бүрдүүлнэ. Үүнд:

- Хуульчдын холбоо бүр гишүүдээсээ гурван төлөөлөгч томилох;
- Хуульчдын холбоонд бүртгэлтэй гишүүнчлэлийн тоо тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 100 буюу түүнээс бага тохиолдолд өмнөх тоогоор, зуугаас илүү гарсан 100 гишүүн тутамд нэмэлтээр нэг төлөөлөгч томилох.

Австрали Улсын Хуульчдын холбооны Зөвлөлийн бүрэлдэхүүнд муж улс, бүс нутгийн Хуульчдын холбооны төлөөлөл тус бүр нэг, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Өмгөөллийн сургалтын зөвлөлийн дарга, Санхүү хариуцсан менежер болон Нарийн бичгийн дарга байна. Хуульчдын холбоо бүр нэг төлөөллөө сонгох ба бусад албан тушаалтнуудыг өөрсдөө сонгох замаар бүрдүүлдэг. Ерөнхийлөгчийг дүрэмд зааснаар жил бүрийн ээлжит хурлаас сонгох бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нэг жил байна. Холбооны бусад албан тушаалтныг мөн адил Их хурлаас сонгоно.

Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн Зөвлөлийн гишүүдийг гурван жилийн хугацаагаар сонгох ба жил бүрийн наймдугаар сарын сүүлчийн Баасан гарагт багтаан Зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуулийн өдөр, бүрэн эрх нь дуусаж байгаа Зөвлөлийн гишүүдийн нэр, дахин сонгогдох эрхтэй Зөвлөлийн гишүүдийн мэдээлэл болон тэдгээр гишүүн Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх боломжтой талаарх мэдэгдлийг солиситоруудад хүргүүлнэ.

- Хэрэв нэр дэвшүүлэх хугацаа дуусахаас өмнө нэр дэвших хүсэлт ирүүлсэн гишүүдийн тоо нь сонгуулиар сонгох сул орон тоотой тэнцүү буюу түүнээс бага байх тохиолдолд Нарийн бичгийн дарга нь аль нэр дэвшигч гурван жилийн хугацаагаар, аль орон тоонд сонгогдож байгааг шууд тодорхойлно.
- Нэр дэвших хүсэлт ирүүлсэн гишүүдийн тоо нь сонгуулиар сонгогдох Зөвлөлийн гишүүдийн тооноос илүү байх тохиолдолд Зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуулийн санал хураалт явагдана. Есдүгээр сарын сүүлийн долоо хоногт Хуульчдын нийгэмлэг сонгуульд санал өгөх эрх бүхий солиситор гишүүн бүрд Зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж буй нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, санал авах хуудсыг илгээнэ. Дүрэмд зааснаар Зөвлөлийн гишүүн сонгох сонгуульд зөвхөн бүртгэлтэй солиситор гишүүд санал өгөх эрхтэй байна.
- Гишүүдээс нийт саналын хуудсыг хүлээн авсан болон цахимаар санал өгсөн тохиолдолд цахим санал авах зааврын дагуу санал авна.
- Тооллогын комиссын гишүүд саналын хуудасны бүрэн бүтэн байдлыг шалган, хүчингүй болон албан бус саналын хуудсыг хасаж саналын хуудсыг тоолно. Ээлжит хурал дээр сонгогдсон нэр дэвшигчдийг зарлана.

Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн Ерөнхийлөгчийг дүрэмд зааснаар Зөвлөлийн хурлаас сонгоно. Ерөнхийлөгч нь Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан менежер болон өмнөх жилийн Ерөнхийлөгчийн хамт Хуульчдын нийгэмлэгийн албан тушаалтан байна. Албан

тушаалтнуудыг Зөвлөлийн хурлаас сонгох ба уг хурлыг ээлжит хурал хуралдсаны дараа Зөвлөлийн анхны хурлаар сонгох бөгөөд энэ хурлыг арван хоёрдугаар сард багтаан хуралдуулна. Ерөнхийлөгчийг нэг жилээр томилох бөгөөд Ерөнхийлөгчийн албан тушаалаас буусны дараа өмнөх жилийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг нэг жил хашна. Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр нэг жил ажилласны дараа Ерөнхийлөгчөөр календарийн нэг жил ажиллана.

ОХУ-ын Хуульчдын Холбооны Их хуралд оролцсон хуульчдын төлөөлөгчдийн санал хураалтаар Холбооны зөвлөлийн гишүүд болон Ерөнхийлөгчийг сонгож, чөлөөлдөг тогтолцоотой.

АНУ, постсоциалист орнуудад Зөвлөлийн гишүүд болон Ерөнхийлөгчийг Их хурал/Төлөөлөгчдийн танхимаас сонгодог бол Австрали Улсын Хуульчдын нийгэмлэгийн Зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуулийг тусгайлан зарлаж, сонгодог онцлогтой. Харин Япон Улсын хувьд Зөвлөлийн гишүүдийг хувь тэнцүүлэх байдлаар томилдог. Түүнчлэн Австрали Улсын Хуульчдын холбооны хувьд Зөвлөлийг сонгож бүрдүүлдэг байна. Харьцуулан судалсан улс орнуудын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурваас таван жил буюу харьцангуй урт хугацаатай байгаа нь Зөвлөл өргөн хүрээний бүрэн эрх хэрэгжүүлдгээс гадна Холбооны удирдлага, бодлого, журмын хэрэгжилтийн тогтвортой, уялдаа холбоотой байдлыг хангах зорилготой ажээ. Ерөнхийлөгчийг Хуульчдын холбооны эрх барих дээд байгууллагаас сонгодог бол Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэгийн Ерөнхийлөгчийг Зөвлөлийн гишүүд дундаас сонгодог онцлогтой байна.

ДҮГНЭЛТ

Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн бус байгууллага, нээлттэй компани гэсэн хуулийн этгээдийн хэлбэрээр, хуулиар эсхүл гишүүдийн сайн дурын нэгдэл болж үүсгэн байгуулагддаг ажээ. Гишүүнчлэл нь сайн дурын болон заавал гэсэн үндсэн хоёр төрлөөр явагддаг. Тухайлбал, АНУ, ОХУ, Беларусь Улсын Хуульчдын холбоо нь сайн дурын гишүүнчлэлтэй олон нийтийн нэгдэл байгаа бол Япон, Литва улсуудын Хуульчдын холбоо нь заавал гишүүнчлэлтэй нийтийн эрх зүйн хуулийн этгээд, харин Австрали Улсын Хуульчдын нийгэмлэг нь сайн дурын гишүүнчлэлтэй нээлттэй компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Гишүүний оролцоо, идэвх, эрхэлж буй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, гишүүдийн эдлэх эрх, гишүүнчлэлийн хураамжийн хэмжээнээс хамаарен гишүүнчлэлийг мөн төрөлжүүлжээ. Тодруулбал, АНУ, Австрали Улс, Япон Улсад гишүүнчлэлийн төрлөөс хамаарч зарим гишүүн ээлжит хуралд оролцох, санал өгөх, Зөвлөл, Ерөнхийлөгч, сонгогддог бусад албан тушаалд нэр дэвших, тэдгээрийг сонгох эрхтэй бол зарим гишүүн эдгээр эрхийг эдэлдэггүй онцлог зохицуулалттай.

Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын бүтэц, зохион байгуулалт ихэнх оронд ижил төстэй байх бөгөөд эрх барих дээд байгууллага (Хурал), Зөвлөл (*Council*), Ерөнхийлөгч (*Presidents*), Гүйцэтгэх байгууллага (*Executive body*), Хяналтын зөвлөл болон Хороод (*Committees*), бусад орон нутаг, бүс нутгийн холбоод (*Local association*)-той байна.

Холбооны эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлдог боловч үндсэн үйл ажиллагааг дүрмээр зохицуулдаг. Удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг бүртгэлтэй гишүүн болон нийт гишүүний төлөөллөөс

бүрдүүлдэг. Их хурал, Төлөөлөгчдийн танхим, Нэгдсэн хурал гэсэн байгууллагууд нь Холбооны дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг ба хуралдааны давтамж нь нэг жилд хоёр удаа болохоос эхлээд гурван жилд нэгээс доошгүй удаа хуралдан дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, гишүүнчлэлийн төрөл тогтоох, гишүүнчлэлийн төлбөрийн хураамжийн хэмжээг тогтоох, Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Хурлын төлөөлөгчдийг Холбоонд бүртгэлтэй салбар, хороо, орон нутгийн Хуульчдын холбоо, мэргэшлийн холбоодоос нэгээс дээш тооны төлөөлөгч сонгох замаар эсхүл төлөөлөгч сонгохгүйгээр Холбооны гишүүн бүр хуралд оролцох эрхтэй байхаар зохицуулдаг. Их хурлын төлөөлөгчдийн ирц бүрдэх доод тоог дүрмээр тогтоож, хурлаар хэлэлцэх асуудлыг олонхын саналаар шийдвэрлэх зарчмууд нийтлэг байна.

Холбооны удирдлагыг хэрэгжүүлдэг удирдах байгууллага нь Зөвлөл байна. Харьцуулсан судалгаагаар судалсан улс орнуудын хувьд Зөвлөл нь гишүүдийн дагаж мөрдөх журам, шийдвэр гаргах, ээлжит хурлыг зарлан хуралдуулах, төсөв батлах, гишүүдийн сахилгын зөрчилд дүгнэлт гаргах, гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах, Холбоо дүрмийн зорилгоо биелүүлж буй эсэхэд хяналт тавих зэрэг нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлж байна. Мөн Зөвлөл нь чиг үүргээ тухайн асуудлаар мэргэшсэн буюу тодорхой ашиг сонирхол бүхий Хороодоор (жишээ нь: Австрали, АНУ, ОХУ, Литва Улс, Беларусь Улс) дамжуулан хэрэгжүүлэх эсхүл орон нутаг, бүс нутаг, салбарын Хуульчдын холбоод байгуулан (жишээ нь: Япон Улс, Австрали Улс, ОХУ) чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Зөвлөлийн гишүүдэд мэргэжлийн салбар, статусаар эсхүл газар зүйн байршлаар салбар, бүс нутаг, орон нутгаас заасан төлөөллийг сонгон, нэр дэвшүүлдэг ба Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёроос гурван жил байна. Австрали Улс, АНУ, Япон Улсад Зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, өмнөх жилийн Ерөнхийлөгчийг оруулдаг.

Холбооны Ерөнхийлөгч нь хурал зарлах, даргалах, холбоонд бүртгэлтэй орон нутгийн хуульчдын болон өмгөөлөгчдийн холбоотой хамтран

ажиллах, гадаад харилцаанд төлөөлөх зэрэг бүрэн эрхийг нэгээс гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэх ба нийт гишүүдийн эсхүл төлөөлөгчдийн Их хурлаас сонгогддог. Ерөнхийлөгч өөрийн чиг үүргийн хүрээнд Холбооны бусад албан тушаалтан, салбар, хороодын үйл ажиллагаанд чиглэл өгөх, оролцох, томилгоо хийх эрхтэй боловч зарим тохиолдолд саналын эрх эдлэхгүй байх онцлогтой.

Их хурал, Төлөөлөгчдийн танхим, Удирдах зөвлөл, салбар хороодын үйл ажиллагааны холбогдолтой баримт бичгийг төлөвлөх, батлуулах, хадгалах, санхүүгийн бүртгэл, тооцоо хөтлөх, Холбооны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн ил тод байдлыг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтан эсхүл хороог тодорхойлон, тэдгээрийг хэрэгжүүлэх гишүүн, албан тушаалтанд тавигдах шаардлага болон томилж, хяналт тавих эрхийг хэрэгжүүлэх субъектийг Холбооны дүрэмд тухайлан заажээ.

Хуульчдын мэргэжлийн хариуцлагын тогтолцоог хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэгт тусган (АНУ, Япон Улс), хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг хянан шийдвэрлэх тогтолцоог холбооны Их хурлаас байгуулагддаг бие даасан байгууллагаар эсхүл Удирдах зөвлөлийн харьяа тусгай чиг үүргийн хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо нь заавал байх буюу чиг үүргийн хороо байна.

Хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй хуульчид Холбооны үйл ажиллагаанд шууд бусаар, сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан буюу Их хурлын төлөөлөгч, Зөвлөлд сонгосон төлөөлөөрөө дамжуулан оролцож байна. Их хурлын төлөөлөгч, Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож буй болон Ерөнхийлөгчид нэр дэвшиж буй гишүүдэд гишүүнчлэлийн хугацаа, албан тушаал эрхэлж байсан эсэх, нас, хүйс, нийгмийн цөөнхийн бүлэгт хамааралтай эсэх, хуулийн оюутан байх зэрэг нийтлэг шаардлагуудыг тодорхойлсон байна.

Манай улсын хувьд хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчийн тоо харилцан адилгүй байхад ХЭЗБТХ-ийн төсөлд Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дөрвөн жил болгон, Зөвлөлийн гишүүдийн тоог 25 байхаар өөрчилж, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад

хуульчийн төлөөлөл тус бүр тав байхаар заасан нь сонгогдсон төлөөлөгчид бусад хуульчийн эрх, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлэн, төлөөлж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Иймд Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход бүх хуульчийн оролцоог хангаж, Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагааг хүртээмжтэй, шударгаар явуулахад чиглэсэн заалтуудыг Хуульчдын холбооны дүрэмд нарийвчлан тусгах шаардлагатай.

ХЭЗБтХ-ийн төсөлд Ерөнхийлөгчөөр сонгогдох хугацааг уртасгаснаас гадна одоо үйлчилж буй хууль, дүрэм, журамд зохицуулаагүй байгаа Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан заалтуудыг хуулийн төсөлд тусгаагүй байна.

САНАЛ

Санал 1. Хуульчдын холбооны чиг үүрэгт холбогдох санал

ХЭЗБтХ-ийн төслийн 31.1 дэх хэсэгт зохицуулсан Хуульчдын холбооны гүйцэтгэх чиг үүрэгт дараах чиг үүргүүдийг нэмэх:

- Хуульчийн мэргэжлийн чадварыг дэмжих зорилгоор хэвлэн нийтлэлийн ажил, хууль зүйн судалгааг дэмжих, зохион байгуулах;
- Хуульчийн мэргэжлийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурийг тогтвортой, өндөр хариуцлагатай байлгах, ёс зүйн зөрчил, мэргэжлийн нэр төрийг унагасан үйлдлүүдийг таслан зогсоох;
- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг хараат бус, бие даасан бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх;
- Гишүүдийн ашиг сонирхолд нийцүүлэн үйлчилгээ санал болгох;
- Холбооны хөрөнгийг бие даан удирдах, зарцуулах;
- Хууль тогтоомжийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах явцад мэргэжлийн санал, зөвлөмж өгөх;
- Гишүүдийн эрх ашиг болон хууль зүйн мэргэжлийн нэр хүндийг хамгаалах.

Санал 2. Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтад холбогдох санал

- Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд ХЭЗБтХ-ийн төслийн 31.2 дахь хэсэгт тодорхойлсон Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбогдох гомдлыг

шийдвэрлэх “Мэргэжлийн болон Ёс зүйн хариуцлагын хороо”-той байх зохицуулалт нэмж, тусгах;

- ХЭЗБтХ-ийн 31.3 дахь хэсэгт заасан Холбооны бүтцийн байгууллагад хамаарах “нэгж”, “хороо” байгуулах, татан буулгах эрхийг тодорхой болгон, Удирдах зөвлөлд олгох зохицуулалтыг шинээр нэмэх.

Санал 3. Хуулийн төсөлд тодорхойлсон Их хурлын төлөөлөгчийн квотод холбогдох санал

ХЭЗБтХ-ийн төслийн 32.3 дахь хэсэгт “Их хурал нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчийн төлөөлөл тус бүр 40 буюу нийт 200 төлөөлөгчөөс бүрдэнэ” гэж квот тогтоосныг дараах байдлаар өөрчлөх саналтай байна.

Хуульчдын холбооны гишүүнчлэл жил бүр нэмэгдэх тул мэргэшлийн бүлэглэлээр тэнцүү тооны квот хуваарилан, төлөөлөгчдийн хатуу квот тогтоох нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага дахь хуульчдын идэвх, оролцоо буурах нэг шалтгаан болно.

АНУ болон Нью Йорк муж улсын Хуульчдын холбооноос дээд удирдлагыг хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн танхимын төлөөлөгчдийг сонгоход гишүүнчлэлийн тооноос хамаарч төлөөлөгчийн тоо нэгээр нэмэгдэх байдлаар зохицуулсан бол Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс муж улсын Хуульчдын нийгэмлэг болон Япон Улсын Хуульчдын холбооны гишүүн бүр Хуралд оролцох эрхтэй байхаар зохицуулдаг. Иймээс мэргэшлийн бүлэгт хамаарах гишүүдийн тоог үл харгалзан ижил тооны төлөөлөгч сонгохоор хуулийн төсөлд зохицуулсныг өөрчлөн, МХХ-ны нийт хуульчийг Хуралд оролцох боломжоор хангах нь зүйтэй.

Санал 4. Их хурал зарлан хуралдуулах давтамжид холбогдох санал

ХЭЗБтХ-ийн төслийн 32.2 дахь хэсэгт зааснаар Их хурал дөрвөн жилд нэг удаа хуралдах хугацаа тогтоосныг өөрчлөх санал дэвшүүлж байна.

Харьцуулсан судалгаагаар Хуульчдын холбооны эрх барих дээд байгууллагын ээлжит хурлыг Япон Улсад жилд хоёр удаа, АНУ, Австрали Улсад жил бүр, ОХУ-д гурван жилд нэгээс доошгүй удаа

тус тус зохион байгуулахаар заасан. Эдгээртэй харьцуулахад хуулийн төсөлд тусгагдсан дөрвөн жилд нэг удаа хуралдуулах зохицуулалт нь урт хугацаа бөгөөд одоогийн хуулиар мөрдөж буй хоёр жилийн хугацааг уртасгах хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна.

Санал 5. Хуульчдын холбооны Их хурлын хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар хязгаарлахгүй байх

Холбооны Их хурлын хэрэгжүүлэх бүрэн эрх нь ХЭЗБТХ-ийн төслийн 32.7 дахь хэсэгт заасан дөрвөн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй байх зохицуулалтыг нэмэх санал дэвшүүлж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын эрх бүхий дээд байгууллагын бүрэн эрхийг зөвхөн хуулиар бус (жишээ нь: АНУ, Австрали Улс, Япон Улс, ОХУ, Беларусь) Холбооны дүрмээр зохицуулдаг. Иймд МХХ нь бие даасан, хараат бус байгууллага болохын хувьд Холбооны дүрмээр Холбооны бүтэц, чиг үүрэг, бүрэн эрхийг тогтоох нь зүйтэй.

Санал 6. Хяналтын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа, нийтлэг шаардлагыг тодорхойлох

ХЭЗБТХ-ийн төслийн 36.1 дэх хэсэгт Хяналтын хороог таван гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тусган, тэдгээр нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчийн төлөөллөөс бүрдэх, дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатай байхаар тусгасан байна.

Хяналтын хороо нь Хуульчдын холбооны Их хурлын дараах удирдах түвшний бүтэц бөгөөд АНУ, Австрали Улс, Япон Улс, ОХУ, Беларусь Улсад Хуульчдын холбооны үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх ижил үүрэг бүхий Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нэгээс гурван жил, улиран сонгогдохгүй байхаар зохицуулжээ. Хуульчдын холбооны санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам батлах зэрэг хэрэгжүүлэх бүрэн эрхээс нь хамааран гишүүнд тавигдах ерөнхий шаардлагыг хуулиар тодорхойлох нь зүйтэй. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд төлөөллийг хангалттай түвшинд бүрдүүлэх, Зөвлөлийн гишүүнд нийтлэг тавигдах шаардлагад тодорхой тооны гишүүн нь санхүүгийн мэдлэгтэй байх зэргийг харгалзах шаардлагатай.

Санал 7. Хуульчдын гишүүнчлэлийн хураамжийг тогтооход холбогдох санал

ХЭЗБТХ-ийн төслийн 38.3, 38.4 дэх хэсэгт заасан хуульчийн зөвшөөрлийн хураамжийн зохицуулалтад өөрчлөлт оруулах дараах саналыг дэвшүүлж байна.

Хуульчийн зөвшөөрлийн хураамжийг ялгамжтай тогтоох нь зүйтэй. Тухайлбал, АНУ, Австрали, Япон зэрэг улсад гишүүнчлэлийн төрөл, авч буй үйлчилгээ, Холбооны үйл ажиллагаанд оролцож буй байдлаас хамаарсан ялгаатай хураамжийг Хуульчдын холбооноос тогтоодог. Иймд хуульчийн идэвх оролцоо, санал санаачилга, хүлээн авч буй үйлчилгээнд тулгуурлан гишүүнчлэлийн хураамжийг тогтоох эрхийг Их хуралд олгох байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Санал 8. Хуульчдын холбооны эрх зүйн үндсийг тодорхойлох гол баримт бичиг болох Холбооны дүрмээр заавал зохицуулах харилцааг нэгтгэн, дараах байдлаар тодорхойлох

Холбооны дүрмээр дараах харилцааг зохицуулна. Үүнд:

- Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалтыг тогтоох;
- Хуульчдын Их хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодорхойлох;
- Хуульчдын Их хурлын төлөөлөгчдийг сонгох журам;
- Хяналтын хорооны чиг үүргийг тогтоох;
- Хуульчийн мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагын хорооны чиг үүргийг тогтоох;
- Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Хяналтын хороо, Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдэд тавигдах хууль зүйн шаардлагыг тодорхойлох;
- Сонгуульт албан тушаалд ажиллаж байгаа гишүүн цаашид үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд сул орон тоог хэрхэн нөхөх талаарх зохицуулалтыг тусгах;

- Гишүүнчлэлийн төрөл, төлбөр, хураамжийн хэмжээ;
- Хуульчдын холбооны үйл ажиллагааны санхүүжилт, зарцуулалтыг хөтлөх, бүртгэх, тайлагнах чиг үүргийг тодорхойлох;
- Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ил тод байдлыг хангах талаар.

Санал 9. Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслөөс хасах саналтай зохицуулалтууд

- ХЭЗБТХ-ийн төслийн 20.3 дахь хэсэгт заасан “Хуульч нь шүүгчээр томилогдсон бол Хуульчдын холбооны гишүүнчлэлээс өөрийн хүсэлтээр түдгэлзэж болно” гэснийг хасах;
- ХЭЗБТХ-ийн төслийн 32.5 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 20.3-т заасны дагуу шүүгчийн гишүүнчлэл түдгэлзсэний улмаас Хуульчдын холбооны Их хуралд оролцох шүүгчийн төлөөлөл хүрэлцэхгүй тохиолдолд энэ хуулийн 32.6-д заасан журмын дагуу бусад гишүүний төлөөллөөс бүрдүүлнэ” гэснийг хасах.

Нийгэмд шударга ёсыг сахиулах, хууль дээдлэх ёс, эрх зүйт ёсыг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн болон тэдний өөрийн удирдлагыг хэрэгжүүлж буй Хуульчдын холбооны үндсэн зорилго байхаар АНУ, ОХУ, Япон, Австрали, Литва болон Беларусь улсуудад тодорхойлжээ.

Дээрх зохицуулалтууд нь Хуульчдын холбооны үйл ажиллагаа болон түүний удирдах дээд байгууллагад шүүгчид оролцохгүй байх, оролцоо буурах эрсдэл бий болгосон тул хасах санал дэвшүүлж байна. Шүүгчийн болзол, шаардлагад хууль зүйн мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх үзүүлэлт багтдаг бөгөөд шүүгч болсноос хойш ч тэдгээрийг цаашид хангаж ажиллах шаардлагатай. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, сэргээн тогтоох, шударга ёсыг сахиулах, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх замаар хуульчийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалах нь шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Монгол хэлээрх эх сурвалж

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, УБ., 2012.
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УБ., 2013.
3. Өмгөөллийн тухай хууль, УБ., 2002.
4. Шүүхийн тухай хууль, УБ., 2021.
5. Монгол Улсын Их хуралд 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. <http://forum.parliament.mn/projects/11102>
6. Монголын Хуульчдын холбооны дүрэм, УБ., 2013.
7. Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журам, УБ., 2013.
8. Монголын Хуульчдын холбооны Их хурлын төлөөлөгч сонгох журам, УБ., 2015.
9. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга, үзэл баримтлал. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн эргэн тойронд. http://huulich.blogspot.com/p/blog-page_30.html
10. МХХ, Хууль дээдлэх ёсны баталгаа: Хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага, УБ., 2019.
11. МХХ, Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооноос гаргасан санал, 2015.10.13.
12. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020. <http://forum.parliament.mn/projects/11102>
13. С.Нарангэрэл, Хууль зүйн англи-монгол эх толь, УБ., 2012.
14. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны веб хуудас. <https://mojha.gov.mn/newmojha/>

15. Монголын Хуульчдын холбооны албан ёсны веб хуудас. <https://www.mglbar.mn>
16. Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны болон захиргааны хэргийн анхан шатны шүүхийн веб хуудас. <https://courtda.mn/>

Б. Гадаад хэлээрх эх сурвалж

1. Attorney Act, Act No. 205 of June 10, 1949, <http://www.japanese-lawtranslation.go.jp/law/detail/?id=1878&vm=02&re=02>
2. Corporations Act, 2001, <https://www.legislation.gov.au/Details/C2019C00216>
3. Legal Profession Act 2007, Queensland Legislation. <https://www.legislation.qld.gov.au/view/whole/pdf/inforce/current/act-2007-024>
4. Australian Bar Association Limited Constitution, ABN 14 605 949 148, 2017. https://austbar.asn.au/uploads/pdfs/ABA_Constitution_31_Jan_2017.pdf
5. Article of Association of Japan Federation of Bar Associations, 1949. <https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/articles.pdf>
6. The Bylaws of the New York State Bar Association, 2019. <https://nysba.org/NYSBA/Advocacy%20and%20Leadership/Bylaws%20January%202019.pdf>
7. Constitution and Bylaws, rule of procedure house of delegates, 2020-2021. https://www.americanbar.org/content/dam/aba/administrative/house_of_delegates/constitution-and-bylaws/constitution-and-bylaw/2020-2021-constitution-and-bylaws.pdf
8. Constitution of The Law Society of New South Wales, (ACN 000 000 699). <https://www.lawsociety.com.au/files/2021-10/ConstitutionSocietyNSW.pdf>
9. Legal Profession (Society) Rules 2007, Queensland Law Society. https://www.qls.com.au/getattachment/feb890e8-6210-4f57-be6e-694b0688ee21/qls_society_rules_2007_-_version_29_fnl.pdf
10. Устав общероссийской общественной организации “Ассоциация юристов России”. <https://alrf.ru>
11. Republic of Lithuania Law on the Bar. <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/TAIS.368972?jfwid=tu0odnr57>
12. Устав общественного объединения “Белорусский Республиканский союз юристов”. <https://union.by/%D0%BE-%D0%BD%D0%B0%D1%81/%D1%83%D1%81%D1%82%D0%B0%D0%B2>

13. Basic Rules on the Duties of Foreign Special Members, (Federation’s Rule No. 25 of January 24, 1987). https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/basicrules_foreign.pdf
14. Basic Rules on the Duties of Practicing Attorneys, (Federation’s Rule No. 70 of November 10, 2004). https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/basic_rules.pdf
15. Basic Rules on the Duties of Registered Foreign Lawyers. (Gaikokuho-Jimu-Bengoshi) (Federation’s Rule No. 100 of December 5, 2014). https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/basicrules_registered.pdf
16. Regulations Concerning Client Identity Verification and Record Preservation, 2012. <https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/rccivrp.pdf>
17. Rules on Office Name of Registered Foreign Lawyers (Federation’s Rule No.76 of March 3, 2006). https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/rules_office.pdf
18. Rules Concerning Disclosure of Disciplinary Records. https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/rules_disciprecord.pdf
19. Act on Special Measures concerning the Handling of Legal Services by Foreign Lawyers (Act No. 66 of 1986). <https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/hls.pdf>
20. Ordinance for Enforcement of the Act on Special Measures concerning the Handling of Legal Services by Foreign Lawyers. <https://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/hlsfl.pdf>
21. Протокол №1 Учредительного Съезда Общероссийской Общественной Организации “Ассоциация юристов России”, М., 2005. https://alrf.ru/upload/medialibrary/0ff/Protocol_Uchreditelnogo_seezda_AYR.pdf
22. Федеральный закон от 19.05.1995 N 82-ФЗ, “Об общественных объединениях”. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6693/
23. Положение о региональных и местных отделениях Общероссийской общественной организации “Ассоциация юристов России”. <https://alrf.ru>
24. Положение об окружном Совете Общероссийской общественной организации “Ассоциация юристов в России” в федеральных округах. https://alrf.ru/upload/medialibrary/fb5/Tipovoe_polozhenie_ob_okruznyh_sovetah.pdf

25. Положение о порядке приема в члены Общероссийской общественной организации “Ассоциация юристов России” и ведении Единого реестра Общероссийской общественной организации “Ассоциация юристов в России”. <https://alrf.ru>
26. Положение о Правлении Ассоциации юристов в России. https://alrf.ru/upload/medialibrary/a5c/polojenie_o_pravlenii_aur.pdf
27. Устав общественного объединения “Белорусский Республиканский союз юристов”. <https://union.by/%D0%BE-%D0%BD%D0%B0%D1%81%D1%83%D1%81%D1%82%D0%B0%D0%B2>
28. Professional Conduct Committee Charter. <https://www.qls.com.au/Content-Collections/Charters/Professional-Conduct-Committee-Charter>
29. American Bar Association, Policy and Procedures handbook, 2021-2022. https://www.americanbar.org/content/dam/aba/administrative/board_of_governors/greenbook/greenbook.pdf
30. ABA Profile of the Legal Profession, 2020. americanbar.org/content
31. Comparative analysis of Bar Associations and Law Societies in Select European Jurisdictions, January 2017. <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/28959/121502-WP-ComparativeAnalysisofBarAssociationandLawSocietiesinSelectEuropeanJurisdctionsEN-PUBLIC.pdf?sequence=1&isAllowed=y>
32. Law Societies: To be or not to be a member. <https://www.findlaw.com.au/articles/798/law-societies--to-be-or-not-to-be-a-member.aspx>
33. American Bar Association. <https://www.americanbar.org>
34. The New York State Bar Association. <https://nysba.org>
35. Australian Bar Association. <https://austbar.asn.au>
36. Queensland Law Society. <https://www.qls.com.au>
37. Japan Federation of Bar Associations. 日本弁護士連合会: HOME
38. Федеральная палата адвокатов РФ. <https://fparf.ru/fpa-rf/about/>
39. LIETUVOS ADVOKATŪRA. <https://www.advokatura.lt/ru/>

ISBN: 978-9919-9812-4-2



9 789919 981242